ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/175

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн “Монгол ардын нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Аймгийн “Монгол ардын нам”-ын хорооны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ......... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................../Б.ГАНТУЯА/

Дундговь аймгийн Монгол Ардын Намын
хорооны 2024 оны 06 сарын 20-ний өдрийн
3 дугаар хурлын 02 тоот тогтоолоор батлав.

# АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖИЛ- ДУНДГОВИЙН СЭРГЭЛТ

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Монгол Ардын Намын “Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028” зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх “ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖИЛ- ДУНДГОВИЙН СЭРГЭЛТ” мөрийн хөтөлбөрийн хүрээнд 5 үндсэн бүлэг, 19 дэд бүлэг, 183 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц

1.2 Эрүүл иргэн

1.3 Боловсролтой иргэн

1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого

- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Гэр бүл
- Ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5 Хөдөлмөр эрхлэлт

1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн

1.7 Эрүүл идэвхитэй амьдралын хэвшил бүхий иргэн

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин

3.2 Шинэ ажлын байр

3.3 Төрөлжсөн аялал жуулчлал

**ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ**

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

**ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ**

5.1 Тэрбум мод хөтөлбөр

5.2 Уламжлалт нүүдлийн мал аж ахуй

5.3 Үнэт баялаг ус

**ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

6.1 Бүтээн байгуулалт

6.2 “Шинэ Мандалговь” хөтөлбөр

6.3 Сумдын хөгжил



4817144213
ЗЮА0039 9033475

# 1 НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг өнөөгийн түвшнээс 5 дахин нэмэгдүүлнэ.

1.1.2 “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төв болон сумдын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмадуудыг нэн түрүүнд хамруулна.

1.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.

1.1.4 “ 1000 айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, аймгийн төвд 700 айл, сумдад 300 айлын орон сууцыг нэмж барина.

### *1.2 Эрүүл иргэн*

1.2.1 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн, эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.2.2 Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн хийх, эрүүл, зөв хооллолтыг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3 Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтнуудыг гадаад, дотоодод сургах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.4 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.5 “Элэг бүтэн Монгол”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” болон хүүхдийн “Эрүүл шүд” хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, үргэлжлүүлнэ.

1.2.6 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, “Эрт илрүүлэг” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.7 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтнуудыг жил бүр шалгаруулж, эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн*

1.3.1 ОХУ-ын хөрөнгө оруулалттай, олон улсын жишигт нийцсэн, бүсийн хэмжээний ЕБ-ийн сургууль байгуулна.

1.3.2 Политехник коллежийн сургалтын орчныг сайжруулж, Говийн бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлнэ.

4817144213

1.3.3 Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн, холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, томилно.

1.3.4 Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, ТМБС, ЕБС, СӨБ-ын байгууллагын багш нарыг гадаад, дотоодод сургаж, бэлтгэх бодлого баримтална.

1.3.5 Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж, сургалт, үйл ажиллагаанд хамруулна.

1.3.6 Бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдад англи хэл эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, англи хэлний багш нарыг гадаадад сургаж чадавхжуулна.

1.3.7 Аймгийн хэмжээнд цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгуудыг бүрэн шинэчилж засварлана.

1.3.8 Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг 100 хувь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.3.9 Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбайг байгуулна.

1.3.10 "Байгалийн ухаан" болон "Математик", "Англи хэл", "Оюунлаг Дундговь" дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, улс, бүсийн хэмжээний төрөлжсөн олимпиадыг аймагтаа тогтмол зохион байгуулна.

1.3.11 Сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилтнуудыг жил бүр шалгаруулж, боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.12 Залуу багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.13 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

1.3.14 Багшийн хүрэлцээгүй сумдад цахимаар ажиллах нөхцлийг бүрдүүлж, багш нарыг давхар ажиллаж, цалин орлогоо нэмэгдүүлэх боломжтой болгоно.

1.3.15 Ахмад багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санг сургууль бүрийн дэргэд байгуулна.

### *1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого*

**Хүүхэд**

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

ЗЮА0039 9033475

1.4.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан, ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулна.

1.4.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй, эрсдэлт бүлгийн суралцагчдад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.4.5 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээлтэй, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.4.6 Цэцэрлэг, сургуулийн дотоод, гадаад орчинг бүрэн камержуулж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлнэ.

**Оюутан, залуучууд**

1.4.7 Оюутны цагаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журмын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, цагийн ажлын зуучлалыг E-Student цэсээр дамжуулан зохион байгуулна.

1.4.8 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

1.4.9 Хөдөлмөрийн хуулинд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж, шинээр ажлын байр бий болгох бодлого баримтална.

1.4.10 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.4.11 "Хийнгээ суръя- Орлого олъё-Хэмнэе" загвараар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлнэ.

1.4.12 Орчин үеийн стандартад нийцсэн кино театрын барилга барина .

1.4.13 Залуучуудын хөгжлийн төв байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

**Гэр бүл**

1.4.14 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.15 Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй тогтолцоог хөгжүүлнэ.

1.4.16 Цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийг уртасгаж эцэг, эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.17 Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.

1.4.18 Айл өрхийн амьжиргааны түвшинг олон улсын аргачлалаар тогтоож, ажил орлоготой болгох, малжуулах, туслах аж ахуй эрхлүүлэх зэргээр орлогын өсөлтийг дэмжих бодитой арга хэмжээг авч ажиллана.

4817144213
ЗЮА0039 9033475

**Ахмад настан**

1.4.19 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
1.4.20 Аймагт ахмадын сувилал байгуулж, ахмадуудыг орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлнэ.
1.4.21 Түрээсийн орон сууцны хөтөлбөрт ахмадуудыг хамруулан, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэнэ.
1.4.22 Говийн бүсийн асрамжийн газрыг аймагтаа байгуулж, харж хандах хүнгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамжийн үйлчилгээ үзүүлнэ.
1.4.23 Ахмадуудын урлаг, спортын наадмыг аймагтаа бүсчилэн зохион байгуулна.
1.4.24 Нарийн мэргэжлийн оношлогооны төвд 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар оношуулж, зардлыг эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.
1.4.25 Аймгийн төвд “Ахмадын эмнэлэг” байгуулна.
1.4.26 Сумын ахмадын хорооны дарга нарын урамшууллыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
1.4.27 Ахмад настнуудад өдрийн болон 7 хоногийн эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх геронтологийн төв байгуулна

**Малчид**

Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:

1.4.28 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмшүүлэх, ашиглуулах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.
1.4.29 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
1.4.30 Говийн бүсийн хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.
1.4.31 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.
1.4.32 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.
1.4.33 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
1.4.34 Зудын эрсдэлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөл хэрэгжүүлнэ.
1.4.35 Бүх сумдын эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр ханган, Старлинкийн интернетэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.

ЗЮА0039 9033475

1.4.36 Малчдын эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох ундны усыг стандартын түвшинд хүргэж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

1.4.37 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, аймгийн хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

1.4.38 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.39 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асрамжийн төвийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжинэ.

1.4.40 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

1.4.41 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

***1.5 Хөдөлмөр эрхлэлт***

1.5.1 Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлого баримтлана.

1.5.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.5.3 Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.5.4 Хүнсний нөөц нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулахад чиглэсэн аж ахуй эрхлэх, шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлагыг хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.5.5 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.5.6 Өөрийн нөөц бололцоогоо дайчлан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийг 10-аас доошгүй номинацаар шалгаруулж “Оны шилдэг бүтээгдэхүүн” ном хэвлүүлж үйл ажиллагааг нь сурталчилна.

***1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн***

1.6.1 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгыг ашиглалтад оруулна.

1.6.2 Уртын дууч, морин хуурчдын III их наадмыг зохион байгуулна.

1.6.3 Соёл, урлагийн ажилтнуудын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулж, жил бүр шилдэг ажилтнуудыг шалгаруулан, гадаад, дотоодын арга хэмжээнд оролцуулж, туршлага судлуулна.

1.6.4 Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

1.6.5 Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

4817144213

*1.7 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн*

1.7.1 Мандалговь хотод усан бассейн бүхий спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.

1.7.2 Иргэдийн идэвхитэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуйн зориулалтын зам талбайг нэмэгдүүлж байгуулна.

1.7.3 Дундговь аймгийн "Бага Олимп" спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

1.7.4 Улс бүсийн аварга шалгаруулах үндэсний болон олимпийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

***2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл***

2.1.1 Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи, инновацид суурилан, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.

2.1.2 Аймагтаа говийн бүсийн гойд ашиг шимт цөм сүргийг бий болгоно.

2.1.3 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, сум дундын хоршоог бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.

2.1.4 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.

2.1.5 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.6 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.

2.1.7 Сум бүрт стандарт шаардлага хангасан өвс, тэжээлийн агуулах шинээр барьж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.8 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, аймгийн хэрэгцээг хангана.

2.1.9 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж, уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.1.10 Говийн бүсийн мах, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэр технологийн парк байгуулж, дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.

2.1.11 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

2.1.12 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

**ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

4817144213
ЗЮА0039 9033475

### 3.1 Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин

3.1.1 Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.

3.1.2 Мандалговь хотод жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан бизнес инкубатор төв байгуулна.

3.1.3 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, болон дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдаа болон "Дундговь түншлэл" арга хэмжээг жил бүр зохион байгуулж үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин, сурталчилна.

3.1.4 БНХАУ, ОХУ, Өмнөд Солонгос, Япон, Чех зэрэг улс орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлж, шинээр боломжит улс орнуудтай харилцаа тогтооно.

3.1.5 Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын "Discover Dundgovi" зөвлөгөөнийг зохион байгуулж, орон нутагт хөрөнгө оруулалтыг татна.

### 3.2 Шинэ ажлын байр

3.2.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тодоор олгох зарчмыг хэрэгжүүлнэ.

3.2.2 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

3.2.3 Ажлын байрыг шинээр бий болгосон бүс, орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.

3.2.4 Гараааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.5 Гарааны бизнес эрхлэгч, инноваци, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлогоор дэмжинэ.

3.2.6 "Пассив" хаусын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.2.7 Аймгийн хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

3.2.8 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

3.2.9 Орон нутгийн байгалийн баялаг, ашигт малтмалд түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулна.

### 3.3 Төрөлжсөн аялал жуулчлал

3.3.1 "GoMongolia" хөтөлбөрийн хүрээнд аймагт зочлох гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4317144213
ЭЮА0030 0033475

3.3.2 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.

3.3.3 Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.3.4 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /Айрагны баяр, тэмээний баяр, ардын урлагын наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна.

3.3.5 Их газрын чулуу, Бага газрын чулуу, Онгийн хийд, Цагаан суварга, Өөш манхан, Морин толгойн цав, Дэл уул зэрэг аялал жуулчлалын төвүүдийг байгуулж орон нутгийн аялал жуулчлалын сүлжээг олон улсын аялалын бүстэй холбоно.

3.3.6 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.7 Аялал жуулчлалын гадаадад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа маркенгийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.3.8 Аймаг сумдын орох гарах хаалга, олон нийтийн худалдаа үйлчилгээний төвүүдэд түшиглэн, ариун цэврийн байгууламж бүхий нийтийн бие засах газруудыг бий болгоно.

3.3.9 Их газрын чулуу, байгалийн задгай театрыг түшиглэсэн, аялал жуулчлалын цогцолбор байгуулна.

## ДӨРӨВ.ШУДАРГА ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

### *3.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа*

3.4.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

3.4.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

3.4.3 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

3.4.4 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж, шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

3.4.5 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

ЗЮА0039 9033475

3.4.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

***3.5 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ***

3.5.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.5.2 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

3.5.3 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

3.5.4 “Мандалговь хот”-ын удирдлагын төвийг бий болгоно.

3.5.5 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгох.

**ТАВ.ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ**

***3.6 “Тэрбум мод” хөтөлбөр***

3.6.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

3.6.2 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

3.6.3 Ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

3.6.4 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.

3.6.5 Сум бүрт нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн мод тарих идэвх сонирхлыг нэмэгдүүлнэ. Үүнд: гэр бүл бологсдын, төгсөлтийн, алдар цолтны, бурхан бологсдын гэх мэт

3.6.6 Онгийн гурван хийд /Сайхан-Овоо/, Чойрын хийд /Дэлгэрцогт/, Булаг билүүний хийд /Өлзийт/, Зуутын хийд /Адаацаг/, Үнстий цагаан овооны хийд /Эрдэнэдалай/ зэрэг газруудад номын мэргэдийн дурсгалд зориулсан цэцэрлэгт хүрээлэнг лам хуврага, сүсэгтэн олны дэмжлэгтэйгээр байгуулна.

***3.7 Уламжлалт нүүдлийн мал аж ахуй***

3.7.1 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

3.7.2 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.7.3 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

3.7.4 Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

3.7.5 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

3.7.6 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

***3.8 Үнэт баялаг ус***

3.8.1 Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.

3.8.2 Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг үйлдвэр, уул уурхайг дэмжинэ.

3.8.3 Уул уурхайд үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.

3.8.4 Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн усыг 100 хувь халдваргүйжүүлж мод тарих, ногоон байгууламжид дахин ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.

3.8.5 Аймаг, сумын төвийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усны хайгуул судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлнэ.

**ЗУРГАА.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

***6.1 Бүтээн байгуулалт***

6.1.1 Говийн бүсийг усаар хангах Орхон-Онги төслийн хүрээнд усалгаатай газар тариалан, мод үржүүлгийн газруудыг бий болгоно.

6.1.2 Байгаль, газарзүйн онцлогт түшиглэн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

6.1.3 Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх тохиромжтой дөрвөн байршлыг санал болгож, хүсэлт гаргасан хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

6.1.4 Говийн бүсийн нар, салхины нөөцийг ашиглан, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний станцуудыг байгуулна.

6.1.5 Говийн босоо тэнхлэгийн Тавантолгой-Мандалговь чиглэлийн 230 км төмөр замыг барина.

6.1.6 Мянганы төмөр замын хэсэг Мандалговь-Чойр чиглэлийн 180 км төмөр замыг барьж хүрэн нүүрсийг Бичигт боомтоор гаргана.

6.1.7 Арвай хээр- Мандалговь-Чойр чиглэлийн авто замыг шинээр барина.

6.1.8 Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замыг шинэчлэн засварлана.

6.1.9 Зарим сумдыг аймгийн төв болон төв замтай хатуу хучилттай автозамаар холбоно.

6.1.10 “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн шинэчлэн засварлана.

6.1.11 Мандалговь хотод хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр шинээр барьж, сумдын хог хаягдалын менежментийг сайжруулна.

6.1.12 Салхитын уурхайгаас Их газрын чулуу, байгалийн задгай театр хүртэл эрчим хүчний шугам татна.

**6.2 *“Шинэ Мандалговь”***

6.2.1 Дулааны станцыг барьж дуусган, 2 дугаар хэлхээний шугам сүлжээг шинээр угсарч, ашиглалтад оруулна.

6.2.2 Мандалговь шинэ суурьшлын бүсийг 0,6кВ болон 0,4кВ-ийн хуваарилах сүлжээ бүхий цахилгаан хангамжаар бүрэн хангана.

6.2.3 Бохир зайлуулах шугам сүлжээг өргөтгөнө.

6.2.4 Хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлж, А бүсийн шороон зам, гарцуудыг 100 хувь засмал зам болгож тоосжилтыг багасгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

6.2.5 “Өндөр ээж” төвийн уулзвараас ШШГГазар, Баруун цагаан дэлгүүр, Хуучин наадмын талбай хүртэлх босоо тэнхлэгийн 3.9 км хатуу хучилттай авто зам шинээр барина.

6.2.6 Борооны ус тогтдог автозамуудын ус зайлуулах шугамыг бүрэн шинэчилнэ.

6.2.7 Одоо ашиглагдаж байгаа хатуу хучилттай автозамуудыг дахин шинээр хучих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

6.2.8 Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

6.2.9 “Шинэ гудамж”, “Шинэ хороолол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.2.10 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон, хаус/ орон сууцны хангамжыг нэмэгдүүлж, инжнерийн хангамжтай сууцаар хангана.

6.2.11 Хуучин ашиглалтгүй болсон барилгуудыг буулгаж, орчин үеийн шинэ барилга барих хувийн хэвшлийг дэмжинэ.

6.2.12 Мандалговь хотын айл өрхийн нүхэн жорлонг эко 00 болгоно.

6.2.13 Мандалговь хотын үерийн ус зайлуулах далан, сувгийг бүрэн барьж дуусгана.

***6.3 Сумын хөгжил***

6.3.1 Сум бүрд төрийн албан хаагчдын 12-24 айлын орон сууц барина.

6.3.2 Хулд, Дэлгэрхангай, Адаацаг, Дэрэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Цагаандэлгэр, Сайхан-Овоо, Дэлгэрцогт суманд төвийн шугам сүлжээ /Цэвэр, бохир усны шугам/ цэвэрлэх байгууламж шинээр барьж, сумын төвийн айл өрхийн амьдрах орчинг сайжруулна.

6.3.3 Өндөршил, Өлзийт, Луус, Цагаандэлгэр суманд Эрүүл мэндийн төв, Гурвансайхан суманд Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг шинээр барина.

6.3.4 Сайнцагаан суманд 9,10-р цэцэрлэгийг шинээр, Цагаандэлгэр, Адаацаг, Хулд суманд Хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барина.

6.3.5 Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Өлзийт, Хулд суманд сургуулийн барилгыг шинээр барина.

6.3.6 Дэлгэрцогт, Говь-Угтаал, Адаацаг суманд сургуулийн дотуур байрыг шинээр барьж, ашиглалтад оруулна.

6.3.7 Адаацаг, Өндөршил, Гурвансайхан, Дэрэн, Говь-Угтаал, Сайхан-Овоо суманд Соёлын төвийн барилгыг шинээр барьж, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулна.

6.3.8 Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Өндөршил Баянжаргалан, Луус, Хулд, Сайхан-Овоо, Адаацаг, Дэрэн суманд Нутгийн удирдлагын барилга шинээр барина.

6.3.9 Гурвансайхан, Өндөршил, Баянжаргалан, Говь-Угтаал сумдад ахмадын өргөө байгуулна.

6.3.10 Сумдад нийтийн биеийн тамирын цогцолбор зал, гадна талбайг байгуулж, Говь-Угтаал сумын спорт залны барилгыг ашиглалтад оруулна.

6.3.11 Сумын төвүүдийн дэргэд 3 километрээс багагүй урттай ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.3.12 Сум бүрд шаардлага хангасан халуун усны тогтмол үйлчилгээг бий болгоно.

6.3.13 Говь-Угтаал суманд 10/0,4кВ-ын 400кВА КТПН 10 кВ-ын ЦДАШ барина.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН МАН-ЫН ХОРОО**

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/161

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ
СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Адаацаг сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Адаацаг сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Адаацаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр ( 10 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Адаацаг сумын Сонгуулийн хороонд

Хавсралт 10 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ....................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ............./Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ....................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ........./Б.ГАНТУЯА/

# 2024 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АДААЦАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖИЛ- ДУНДГОВИЙН СЭРГЭЛТ

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", "Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийн хүрээнд 6 үндсэн бүлэг, 118 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц
1.2 Эрүүл иргэн
1.3 Боловсролтой иргэн
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого

- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Гэр бүл
- Ахмад настан
- Малчид
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5 Хөдөлмөр эрхлэлт
1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
1.7 Эрүүл идэвхитэй амьдралтай иргэн

## ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин
3.2 Шинэ ажлын байр
3.3 Төрөлжсөн аялал жуулчлал

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

4817144213
ЗЮА0039 9033475

# ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

5.1 Тэрбум мод хөтөлбөр
5.2 Уламжлалт нүүдлийн мал аж ахуй
5.3 Үнэт баялаг ус

# ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

6.1 Сумын хөгжил

4817144213
ЗЮА0039 0033475

## ЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.2 "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмадуудыг нэн түрүүнд хамруулна.

### *1.2 Эрүүл иргэн*

1.2.1 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн, эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.2.2 Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн хийх, эрүүл, зөв хооллолтыг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3 Эмнэлгийн тусгай тоноглолтой автомашин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.4 "Элэг бүтэн Монгол", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" болон хүүхдийн "Эрүүл шүд" хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, үргэлжлүүлнэ.

1.2.5 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, "Эрт илрүүлэг" хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.6 Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, амьдрах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн*

1.3.1 Багшлах хүний нөөцийг чадавхжуулж ЕБС, СӨБ-ын байгууллагын багш нарыг сургаж, бэлтгэх бодлого баримтална.

1.3.2 Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна.

1.3.3 Бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдад англи хэл эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, англи хэлний багш нарыг сургаж чадавхжуулна.

1.3.4 Сумын дунд сургуулийн барилгыг их засварт оруулан сурагчдын сурах орчин нөхцлийг сайжруулна.

1.3.5 Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбайг байгуулна.

1.3.6 Сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилтнуудыг жил бүр шалгаруулж, боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.7 Залуу багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.8 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

4817144213
ЗЮА0030 9033475

1.3.9 Багшийн цахимаар ажиллах нөхцлийг бүрдүүлж, багш нарыг давхар ажиллаж, цалин орлогоо нэмэгдүүлэх боломжтой болгоно.

1.3.10 Сумын сургууль,цэцэрлэгийн дутагдалтай орон тоог хангаж ажиллана.

## ***Үн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого***

### Хүүхэд

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан, ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулна.

1.4.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй, эрсдэлт бүлгийн суралцагчдад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.4.5 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээлтэй, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.4.6 Цэцэрлэг, сургуулийн дотоод, гадаад орчинг бүрэн камержуулж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлнэ.

### Оюутан, залуучууд

1.4.7 Сумын дутагдалтай байгаа мэргэжлээр сурч байгаа оюутантай гэрээ байгуулан, сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлж, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

1.4.8 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гараааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.4.9 Залуу гэр бүлийг ажлын байранд зуучлан, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

### Гэр бүл

1.4.10 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.11 Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй тогтолцоог хөгжүүлнэ.

1.4.12 Хүүхдийн цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийг уртасгаж эцэг, эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.13 Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.

1.4.14 Айл өрхийн амьжиргааны түвшинг олон улсын аргачлалаар тогтоож, ажил орлоготой болгох, малжуулах, туслах аж ахуй эрхлүүлэх зэргээр орлогын өсөлтийг дэмжих бодитой арга хэмжээг авч ажиллана.

### Ахмад настан

1.4.15 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.16 Түрээсийн орон сууцны хөтөлбөрт ахмадуудыг хамруулан, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэнэ.

1.4.17 Ахмадуудын урлаг, спортын наадмыг зохион байгуулна.

4817144213
ЗЮА0039 9033475

1.4.18 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар оношлуулж, зардлыг эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.
1.4.19 Сумын ахмадын өргөө шинээр барина.

**Малчид**

Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:

1.4.20 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмшүүлэх, ашиглуулах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.
1.4.21 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
1.4.22 Сумын хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.
1.4.23 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.
1.4.24 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
1.4.25 Зудад өртсөн малчдыг малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
1.4.26 Зудын эрсдэлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөл хэрэгжүүлнэ.
1.4.27 Малчдын эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох ундны усыг стандартын түвшинд хүргэж, хэрэглээнд нэвтрүүлнэ.
1.4.28 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, сумын хэмжээнд бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

1.4.29 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.
1.4.30 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг өргөжүүлнэ.
1.4.31 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

***өдөлмөр эрхлэлт***

жлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлого баримтлана.

1.5.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
1.5.3 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
1.5.4 Өөрийн нөөц бололцоогоо дайчлан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг төсөл хөтөлбөр хүү багатай зээлэнд хамруулан үйл ажиллагааг нь сурталчилна.

4817144213
ЗЮА0039 9033475

***1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн***

1.6.1 Соёл, урлагийн ардын авъястнуудыг тодруулж жил бүр шилдэг авъяастнуудыг шалгаруулан аймаг улсын чанартай уралдаан тэмцээнд оролцуулж, туршлага судлуулна.
1.6.2 Иргэд, байгууллага, багуудын дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна.
1.6.3 Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.
1.6.4 Уламжлалт гар урлал, эд хэрэгсэл, нүүдлийн соёл, ёс заншилтай холбоотой арга ухааныг түгээн дэлгэрүүлнэ.

### *1.7 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн*

1.7.1 Иргэдийн идэвхитэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуй ундаг иргэдийн тоог нэмэгдүүлэн идэвхжүүлнэ.
1.7.2 Сумандаа “Бага Олимп” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.
1.7.3 Аймгийн аварга шалгаруулах үндэсний болон олимпийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

## ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл*

2.1.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулна.
2.1.2 Сумандаа гойд ашиг шимт цөм сүргийг бий болгоно.
2.1.3 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, хонины нэхий боловсруулах бага оврын үйлдвэр байгуулна.
2.1.4 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.
2.1.5 Малчдын залгамж халааг бэлтгэх бодлого хэрэгжүүлнэ.
2.1.6 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.
2.1.7 Сумандаа стандарт шаардлага хангасан өвс, тэжээлийн агуулах шинээр барьж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
2.1.8 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, сумын хэрэгцээг хангана.
2.1.9 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж, уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
2.1.10 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.
2.1.11 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3ЮА0039

***изнес, хөрөнгө оруулалтын таатай орчин***

3.1.1 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин, сурталчилна.

3.1.2 Уламжлалт харилцаатай Сэлэнгэ аймгийн Жавхлант сумтай харилцаагаа өргөжүүлж, хүнсний ногоо, ногоон тэжээл тариалах туршлагыг нэвтрүүлнэ.

3.1.3 Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд ижил төстэй хоршоодын зөвлөгөөнийг сумандаа зохион байгуулж, орон нутагт хөрөнгө оруулалтыг татна.

***инэ ажлын байр***

3.2.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тодоор олгох зарчмыг хэрэгжүүлнэ.

3.2.2 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ.

3.2.3 Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.

3.2.4 Гарааны бизнес эрхлэгчид зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлогоор дэмжинэ.

3.2.5 Сумандаа нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

3.2.6 Орон нутгийн байгалийн түгээмэл тархацтай баялагийг зохистой ашиглан төсөвт орох орлогыг нэмэгдүүлнэ.

***3.3 Төрөлжсөн аялал жуулчлал***

3.3.1 Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.3.2 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /Айрагны баяр, тэмээний баяр, ардын урлагын наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна.

3.3.3 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.4 “Сүм хөх бүрд”-ийн хамгаалалтын бүсийг нэмэгдүүлж, тохижилтыг сайжруулан, орон нутгийн болон гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

**ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ**

ЗЮА0039 9033475

### *Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа*

4.1.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

4.1.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

4.1.3 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

4.1.4 Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж, шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

4.1.5 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

4.1.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

### *Иргэдэд ойр төрийн үйлчилгээ*

4.2.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

4.2.2 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

4.2.3 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

4.2.4 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгох.

4.2.5 Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэн нээлттэй, ил тод байлган орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажил үйлчилгээг иргэдийн санаачлагад тулгуурлан чанартай зохион байгуулна.

4.2.6 Сүм багийн контор шинээр барина. Ар Урт багийн конторыг засварлана.

4.2.7 Сумын цагдаагийн кабоны барилгад их засвар хийнэ. Сумын цагдаа, хэсгийн төлөөлөгчийн унааны асуудлыг шийдвэрлэнэ.

ЗЮА0039 9033475

## ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

### *"Тэрбум мод" хөтөлбөр*

5.1.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

5.1.2 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

5.1.3 "Тэрбум" мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.

5.1.4 Зуутын хийдэд номын мэргэдийн дурсгалд зориулсан цэцэрлэгт хүрээлэнг лам хуврага, сүсэгтэн олны дэмжлэгтэйгээр байгуулна.

### *Уламжлалт нүүдлийн мал аж ахуй*

5.2.1 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

5.2.2 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

5.2.3 Газар эзэмшигч, ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

5.2.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

5.2.5 Баг бүрт малыг аюулаас хамгаалах байгууламжийг байгуулна.

5.2.6 Баянхошууны хужирыг хамгаалалтанд авч, ашиглалтыг сайжруулна.

### *Үнэт баялаг ус*

5.3.1 Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.2 Сумын төвийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усны хайгуул судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлнэ.

4317144213
ЗЮА0039 9033475

# ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

## *6.1 Сумын хөгжил*

6.1.1 “1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Суманд төрийн албан хаагчдын 24 айлын орон сууц барина.

6.1.2 Сумын төвийн шугам сүлжээ /Цэвэр, бохир усны шугам/ цэвэрлэх байгууламж шинээр барьж, сумын төвийн айл өрхийн амьдрах орчинг сайжруулна.

6.1.3 Суманд Хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барина.

6.1.4 Суманд сургуулийн барилгыг шинээр ба суманд сургуулийн дотуур байрыг шинээр барьж, ашиглалтад оруулна.

6.1.5 Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулна.

6.1.6 Нутгийн удирдлагын барилга шинээр барина.

6.1.7 Ахмадын өргөөг шинээр барина.

6.1.8 Сумын төвийн ногоон байгууламжыг нэмэгдүүлж, цэцэрлэгт хүрээлэнг тохижуулж, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан чөлөөт цагийг өнгөрүүлэх талбай шинээр байгуулж, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.1.9 Сумын ахуй үйлчилгээний нэр төрлийг олшруулж халуун усны үйл ажилгааг тогтмолжуулна.

6.1.10 Хогийн цэгийг ландфилын аргаар булшилж шинээр хогийн цэг байгуулж, хог ачилтыг тогтмолжуулна.

4817144213
ЗЮА0039 9033475

3

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/167

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Баянжаргалан сумын “Монгол ардын нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Баянжаргалан сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Баянжаргалан сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ....... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................./Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ........................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................./Б.ГАНТУЯА/

# ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: " ШИНЭ ЗУУНЫ СЭРГЭЛТ "

"Алсын харааа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", "Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018 - 2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028", зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилсан мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 24 зорилт, 96 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМ НЬ:

1. Иргэний хөгжлийн бодлогын сэргэлт
2. Сайн засаглалын бодлогын сэргэлт
3. Хөдөө аж ахуйн бодлогын сэргэлт
4. Эдийн засгийн бодлогын сэргэлт
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын бодлогын сэргэлт

## НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН СЭРГЭЛТ

- Эрүүл иргэн
- Боловсролтой иргэн
- Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
- Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн
- Ажилтай, орлоготой иргэн
- Залуучуудын хөгжлийг дэмжинэ
- Ахмадын хөгжлийг дэмжинэ.
- Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

## ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН СЭРГЭЛТ

- Мэргэшсэн чадварлаг төрийн алба
- Шилэн тендерийг зохион байгуулна.
- Хүнд сурталгүй -цахим Баянжаргалан
- Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.
- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН СЭРГЭЛТ

- Малчдын амьжиргааг сайжруулна.
- Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.

- Бэлчээрийн менежментийг сайжруулна.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН СЭРГЭЛТ

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.
- Төр, хувийн хэвшлийн түншлэл.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН СЭРГЭЛТ

- Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.
- Суманд хийгдэх хөрөнгө оруулалт.

## 1. Иргэний хөгжилийн бодлогын сэргэлт

### 1.1 Эрүүл иргэн.

1.1.1 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.3 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн сэргийлэх “СҮҮ” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.4 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.1.5 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.1.6 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

1.1.7 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.1.8 Сумын нийт хүн амын ундны усны уст цэгүүдийг цэвэржүүлэх төхөөрөмжөөр бүрэн хангаж, бүрэн автомат цахим системд шилжүүлнэ.

### 1.2.Боловсролтой иргэн

1.2.1 Сургуулийн орчинд байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.2.2 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.2.3 Иргэдийн боловсролыг дээшлүүлэх, туршлага судлуулах хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2.4 Сургууль Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хүний нөөцтэй болно.

1.2.5 Төгсөөд ажиллаж байгаа залуу багш нарт зориулсан түрээсийн орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ.

1.2.6 Элсэлтийн ерөнхий шалгалтанд бие даан бэлтгэх Цахим хэрэглээний аплейкешнийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

1.2.7 Сум орон нутгаас төрөн гарсан гавьяат багш, дасгалжуулагчдын нэрэмжит тэмцээнийг жил тутам, уламжлал болгон зохион байгуулж боловсролын чанар хүртээмжийг нэмэглүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулна.

**1.3 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн**

1.3.1 “Боржигин өв соёл”-ыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн сурталчилна.

1.3.2 Орон нутгийг судлах танхим болон Музейг бий болгож тохижуулна.

1.3.3 Сур, шагайн харвааг залуу хойч үед өвлүүлэх, сургалт зохион байгуулна.

1.3.4 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарыг олон нийтэд сурталчлан таниулах, тэдгээрийн авьяас чадварыг ирээдүй хойч үедээ сурган өвлүүлэх “Шавь сургалт ”-ыг үе шаттайгаар зохион байгуулна.

**1.4 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн**

1.4.1 Жил бүр уламжлал болгон зохион байгууллагддаг “Гудамж хорооллын тэмцээн”-ийг зохион байгуулна.

1.4.2 “Эрүүл идэвхтэй амьдрах клуб” бий болгоно.

1.4.3 Бие бялдар , идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр “Чийрэгжүүлэлт, аэробикийн клуб”-ийг бий болгох.

**1.5 Ажилтай, орлоготой иргэн**

1.5.1 Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.2 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.5.3 Их дээд болон мэргэжлийн сургуульд суралцаж төгсөх залуучуудыг орон нутагтаа ажиллах боломж нөхцөлөөр хангана.

ЗЮА0039 0033475

1.5.4 “Хүний нөөцийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**1.6 Залуучуудын хөгжлийг дэмжинэ**

1.6.1 Залуучуудын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж, үр дүнг нь нийгэмд сурталчлан таниулна.

1.6.2 Гэр бүл хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв өнгөрөөх бизнес хөгжилийн болон сургалт, боловсролын “Залуучууд ”төв байгуулна.

**1.7 Ахмадын хөгжлийг дэмжинэ**

1.7.1 Ахмад настан, залуучууд, хүүхэд багачуудын гурван үеийн уулзалтыг жил бүр зохион байгуулна.

1.7.2 “Ахмад насны хөгжил хамгааллын үндэс”-ний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.7.3 Ахмадын өргөө барьж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

1.7.4 Нөхөн сэргээх асаргаа сувилгааны танхимыг Эрүүл мэндийн төвийг түшиглэн байгуулна.

**1.8 Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ**

1.8.1 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна.

1.8.2 “Архигүй Баянжаргалан” хөтөлбөрийн хүрээнд нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**1.9. Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил**

1.9.1 Багш, ажилтаны мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчилж, багш өөрөө санаачилгаараа хөгжих тогтолцоог бэхжүүлнэ.

1.9.2 Сургуулийн орчмын орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.9.3 Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг багасгаж, хоол тэжээлийн дутагдалыг тогтвортой бууруулна.

## 2. Сайн засаглалын бодлогын сэргэлт

**2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба**

2.1.1 Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөж, өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэн, хэрэглээг нэмэгдүүлэх.

2.1.2 Төрийн жинхэнэ албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар ханган зохистой тогтолцоог төлөвшүүлнэ.

3IOA0030 9033475

2.1.3 Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ.

2.1.4 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

2.1.5 Авилгаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.1.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ

**2.2 Хүнд сурталгүй -цахим Баянжаргалан**

2.2.1 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг "Нэг иргэн - нэг бүртгэл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.2 Иргэд, олон нийттэй харилцах мэдээллийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төр иргэний эргэх холбоог сайжруулна.

2.2.3 Гэрлэлт бүртгэл, гэрлэлт салалтын талаар угийн бичигт тэмдэглэн үлдээх зохицуулалтыг бий болгож Угийн бичгээ хөтлөх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.

2.2.5 Бүх төрлийн лавлагаа мэдээллийг түргэн шуурхай авах лавлагааны ТҮЦ машинуудыг төрийн үйлчилгээнд ашиглах, нэвтрүүлэх.

2.2.6 Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.2.7 Сумын нэгдсэн вэб сайттай болгоно.

**2.3 Шилэн тендерийг зохион байгуулна.**

2.3.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

2.3.2 Төрийн үйлчилгээний чанарын хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжинэ.

**2.4 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.**

2.4.1 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

2.4.2 Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтлах, ашигт малтмалын хайгуул, ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг жилд 50 га-аас доошгүй хийлгэх.

ЗЮА0035 9053475

2.4.3 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт хийх технологийн замын асуудлыг дэс дараалалтай, үе шаттайгаар шийдвэрлэнэ.

2.4.4 Уул уурхайн шавхалтын усыг ашиглаж хөв цөөрөм байгуулна.

**2.5 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.**

2.5.1 Сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдаж " Сумын хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.2 Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчины менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.3 Хог хаягдлын менежментийг сайжруулна.

2.5.4 Сум хөдөөд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ургамал тариална.

2.5.5 Аргийн хадны байгалийн цогцолбор газарт "Нүгнээч " жуулчны бааз байгуулна.

## 3. Хөдөө аж ахуйн бодлого

**3.1 Малчдын амьжиргааг сайжруулна.**

3.1.1 Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлж эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.1.2 Залуу малчдыг дэмжих зорилгоор бэлчээрийн даац, хороо бууцны зохистой хэрэглээг хангуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1.3 Үхэр сүргийн чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжиж нутгийн шилмэл омгийн үүлдэрийг батлуулан хөгжүүлэх.

3.1.4 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, сумын хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

3.1.5 Тэмээн сүргийг өсгөх "Ботгонд бонус" хөтөлбөрийг өргөн цар хүрээтэйгээр үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**3.2 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.**

3.2.1 Малаас гарах бүтээгдэхүүн , арьс шир ноос ноолуурын бичил төслүүдийг хэрэгжүүлж үйлдвэр цехийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.2.2 "Эрүүл хүнс- Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим,хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

**3.3 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.**

3.3.1 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах ажлыг жил бүр зохион байгуулна.

3.3.2 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо техникчдийг бэлтгэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.3 Мал эмнэлэг үржлийн тасгийн үйл ажиллагааг дэмжиж машин техник хэрэгслээр хангана.

3.3.4 Малын удмын сангийн дата баазтай болгож үйл ажиллагааг нь жигдрүүлэнэ.

**3.4 Бэлчээрийн менежментийг сайжруулна.**

3.4.1 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж бэлчээрт гүн өрмийн болон энгийн уурхайн худаг гаргана.

3.4.2 Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой байгальд халгүй энгийн механик арга болон микробиологийн аргыг хослуулан тэмцэж бэлчээрийг хамгаална.

## 4.Эдийн засгийн бодлогын сэргэлт

**4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ**

4.1.1 Орон нутгийн онцлогтой брэнд хүнсийг дотоод, гадаадын зах зээлд гарах, нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг суманд байгуулахыг дэмжинэ.

4.1.2 Шинэ ургацын ногооны хангалтыг нэмэгдүүлэх, дэмжих

4.1.3 Сумын онцлогт нийцсэн жижиг дунд үйлдвэрлэлийн байр байгуулна.

**4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.**

4.2.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээ / Айрагны баяр, тэмээний баяр, Ардын урлагийн наадам г.м/-г сурталчлах.

4.2.2 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин орлогыг нь нэмэгдүүлнэ.

4.2.3 Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4.2.4 Орон нутгийн үзэсгэлэнт газруудын тойрон аялах маршрут гарган хөтөчтэй болно.

**4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл**

4.3.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлд хөрөнгө оруулалт санхүүжилт татан, бичил бизнес эрхлэгч нарыг дэмжих хөтөлбөр боловсруулна.

4.3.2 Жижиг дунд үйлдвэрлэгчдийн хөгжилийг дэмжих институцийн тогтолцоог бүрдүүлж, хууль, эрх зүйн орчиныг боловсронгуй болгох.

4.3.3 Төрийн болон орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж үр дүнд хүргэнэ.

4817144213
ЭЮА0039 0033475

**4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.**

4.4.1 Сумын хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачилгыг бүрэн дэмжинэ.

4.4.2 Стандартад нийцсэн ресторан, зочид буудал, супер маркетын салбар дэлгүүр байгуулах ажлыг эхлүүлнэ.

4.4.3 Инпортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.

## 5.Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын бодлогын сэргэлт

### 5.2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.

5.2.1 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай сууцаар хангана.

5.2.2 Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг шинээр хийнэ.

5.2.3 Суманд “Шинэ Гудамж”, “Шинэ хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 5.3 Суманд хийгдэх хөрөнгө оруулалт

5.3.1 Сумын төвийн хөгжилийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, явган болон авто замыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.3.2 Нутгийн удирдлагын ордон бүхий спорт цогцолбортой болно.

5.3.3 Ахмадын өргөөний барилга шинээр бариулна.

5.3.4. 40 айлын орон сууц бариулна .

5.3.5 Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн гавьяат эдийн засагч Д.Моломжамцын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн бүхий төв талбай барина.

5.3.6 Сумыг төвийн нийтийн эзэмшилийн гудамж, талбайн Нэгдсэн камержуулалтын системтэй болгоно.

4317144213
ЗЮА0039 9033475

72

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/165

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Говь-Угтаал сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Говь-Угтаал сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн

73

мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говь-Угтаал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ....... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ....................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ....................../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ....................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ....................../Б.ГАНТУЯА/

# СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого""Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх "БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 14 дэд бүлэг, 117 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц
1.2 Эрүүл иргэн
1.3 Боловсролтой иргэн
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого
- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Ахмад настан
- Малчид

1.5 Хөдөлмөр эрхлэлт
1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
1.7 Эрүүл идэвхитэй амьдралтай иргэн

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1 Шинэ ажлын байр

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

4317144213
3IOA0039 0033475

-25-

## ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

5.1 Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд сумын бодлого төлөвлөгөө гаргах
5.2 Уламжлалт нүүдлийн аж ахуйг боловсронгуй болгох, орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурлах

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

6.1 “Бүсийн хөгжлийн төв-Говь-Угтаал сум"

4817144213
ЗЮА0039 9033475

# 1 НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц-нутгийн сэргэлт*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг сумандаа хэрэгжих боломжийг бүрэн бүрдүүлнэ.

1.1.2 "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны барилга барих, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмадуудыг нэн түрүүнд хамруулна.

1.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.1.4 " 36 айлын орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### *1.2 Эрүүл иргэн-нутгийн сэргэлт*

1.2.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.2.2 Сумын эмнэлэгийн статусыг сэргээж бүсийн төв эмнэлэг болгох төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлж ажиллана.

1.2.3 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

1.2.4 Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод сургах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.5 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.6 "Элэг бүтэн Монгол", хүүхдийн "Эрүүл шүд", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

1.2.7 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж "Эрт илрүүлэг" хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.8 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн-нутгийн сэргэлт*

1.3.1 Сумын хүүхдүүдийн боловсролын асуудлыг орон нутгийн тэргүүлэх чиглэл болгон сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хөтөлбөр батлан, хэрэгжүүлж боловсролыг эрс шинэчилнэ.

1.3.2 Сурагчдын хичээлээс гадуурх хөгжлийг нэмэгдүүлж, хот, хөдөөгийн ялгааг багасгаж, олимп, дэлхийн спортыг хөгжүүлнэ.

1.3.3 Англи хэлний хичээлийн тусгай хөтөлбөрийг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлж, сурагчдыг гадаадын их, дээд сургуульд тэтгэлэгээр суралцах суурь боломжийг олгоно. Өндөр түвшний IELTS 7.0 хөтөлбөрийг нэн тэргүүнд хэрэгжүүлнэ.

1.3.4 Сургуульд байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

4317144213
ЗЮА0039 9033475

1.3.5 Төгсөөд ажиллаж байгаа залуу багш нарт зориулсан түрээсийн орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ.
1.3.6 Багшийн хөгжлийг дэмжиж мэргэжил дээшлүүлэх гадаад дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
1.3.7 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.
1.3.8 Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.
1.3.9 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.
1.3.10 Мэргэжлийн багшийн хангалтыг цахим хэлбэрээр болон хамтын ажиллагааны гэрээний түвшинд шийдвэрлэж ажиллана.
1.3.11 Ахмад багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн боловсролыг хөгжүүлэх зөвлөл байгуулан ажиллах асуудлыг дэмжинэ.

## *1.4Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого*

**Хүүхэд-нутгийн сэргэлт**

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
1.4.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
1.4.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулна.
1.4.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
1.4.5 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.
1.4.6 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүчин чадлыг нэмэгдүүлж хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

**Оюутан, залуучууд-нутгийн сэргэлт**

1.4.7 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.
1.4.8 Хөдөлмөрийн хуулинд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж шинэ ажлын байр бий болгох бодлого баримтална.
1.4.9 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.
1.4.10 Төгсөгчдөд зориулан "Хийнгээ суръя- Орлого олъё-Хэмнэе" загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.
1.4.11 Сумын залуучуудын хөгжлийг дэмжиж, шинэ спорт заалны барилгыг түшиглэн залуучуудын бие бялдараа хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв өнгөрөөх боломжийг нээж өгнө.

4817144213
ЗЮА0039 9033475

**Ахмад настан – нутгийн сэргэлт**

1.4.12 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.13 Суманд ахмадын сувилал байгуулж амралт сувилалд явж чаддагүй ахмадуудыг орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлнэ.

1.4.14 Түрээсийн орон сууц барьж, ахмадуудаа хамруулан, төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэнэ.

1.4.15 Ахмадуудын урлаг, спортын наадмыг суманд бүсчилэн зохион байгуулна.

1.4.16 Сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэй оношлогооны төвд 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар хамруулж, зардлыг нь эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.

1.4.17 Сумандаа орчин үеийн шийдэл бүхий, стандартад нийцсэн ахмадын өргөө барих зураг, төсөв хийлгэх, улс, аймаг, сумын төсөв, иргэн, аж ахуйн нэгжийн дэмжлэгээр бариулах асуудлыг шийдвэрлэнэ.

1.4.18 Сумын ахмадын хорооны дарга нарын урамшууллыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

**Малчид-нутгийн сэргэлт**

***Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:***

1.4.19 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.

1.4.20 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

1.4.21 Сумын хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.

1.4.22 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

1.4.23 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг суманд нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.4.24 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.4.25 Нөхөрлөл байгуулж, ажлын байр нэмэгдүүлэх замаар, төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хүн хүч тааруу, ахмад малчдыг зудын эрсдэлээс сэргийлж "ӨВӨЛЖӨӨ" төсөл хэрэгжүүлнэ.

## 1.5 Хөдөлмөр эрхлэлт-нутгийн сэргэлт

1.5.1 Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинийг бууруулах бодлого баримтлана.

1.5.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.5.3 Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.5.4 Хүнсний нөөц нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулахад чиглэсэн аж ахуй эрхлэх, шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлагыг санхүү, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

4317144213
ЗЮА0039 9033475

1.5.5 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

### *1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн-нутгийн сэргэлт*

1.6.1 Соёлын төвийн барилгад их засвар хийж, ая тухтай, орчин нөхцлийг бүрдүүлнэ.
1.6.2 Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна.
1.6.3 Үндэсний өв соёлоо, өвлөн тээгчдийг урамшуулж, сургалт зохион байгуулах боломж бүрдүүлж, олон нийтэд сурталчилан таниулна.
1.6.4 Соёлын ажилтны хүний нөөцийг хانган, үйл ажиллагааг өргөжүүлнэ.
1.6.5 Соёлын төвийн байгууллагыг шинээр байгуулагдаж буй спорт залны барилгатай нэгтгэн “СОЁЛ-СПОРТЫН ЦОГЦОЛБОР” болгон хөгжүүлнэ.
1.6.6 Соёл спортын цогцолборын техник, аппартур, тоног төхөөрөмжийг шинэчилэн, лед дэлгэцтэй болгоно.

### *1.7 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн-нутгийн сэргэлт*

1.7.1 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, ТББ, сонирхолын бүлгүүдээс санаачлан зохион байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
1.7.2 Халдварт бус өвчний эндэгдэлийг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран жил бүр зохион байгуулна.
1.7.3 Суманд “МИНИЙ СУМ” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.
1.7.4 Үндэсний болон олимпийн төрлийн спортыг орон нутагт хөгжүүлнэ.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 2.1 “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл”-нутгийн сэргэлт

2.1.1 .Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.
2.1.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог төрийн дэмжлэгтэй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулж шинэчлэн байгуулна
2.1.3 Сумандаа говийн бүсийн гойд ашиг шимт цөм сүргийг бий болгоно.
2.1.4 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.
2.1.5 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.
2.1.6 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.
2.1.7 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, сумын хэрэгцээг хангана.
2.1.8 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.
2.1.9 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

4817144213
ЗЮА0039 9033475

80

# ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

## 3.1 Шинэ ажлын байр-нутгийн сэргэлт

3.1.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

3.1.2 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

3.1.3 Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.4 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

3.1.5 Орон нутгийн байгалийн баялаг, ашигт малтмалд түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулах бодлого баримтална.

3.1.6 Гидропоник тариалалтын загвар лабортoриыг сумын төвд байгуулж, малчдыг хоршин байгуулах боломжийг бүх талаар дэмжиж, малчид өөрсдөө өвс тэжээлээ бэлтгэх, иргэд ажлын байр бий болгон төсөл хэрэгжүүлэх боломжийг нээж өгнө.

4817144213
ЗЮА0039 9033475

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

### 3.2 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа - нутгийн сэргэлт

3.2.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

3.2.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

3.2.3 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

3.2.4 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

3.2.5 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

3.2.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ..

### 3.3 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ – нутгийн сэргэлт

3.3.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.3.2 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

3.3.3 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

3.3.4 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгох.

4817144213
ЗЮА0039 0033475

## ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

### 3.4 “Тэрбум мод” хөтөлбөр – нутгийн сэргэлт

3.4.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

3.4.2 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

3.4.3 Ногоон сум, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

3.4.4 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.

3.4.5 Суманд нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн мод тарих идэвх сонирхлыг нэмэгдүүлнэ. Үүнд: гэр бүл бологсдын, төгсөлтийн, алдар цолтны, бурхан бологсдын гэх мэт

### 3.5 Уламжлалт нүүдлийн аж ахуй – нутгийн сэргэлт

3.5.1 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

3.5.2 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.5.3 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

3.5.4 Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

3.5.5 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

3.5.6 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

3.5.7 Гидропоник тариалалтын загвар лаборториыг сумын төвд байгуулж, малчдыг хоршин байгуулах боломжийг бүх талаар дэмжиж, малчид өөрсдөө өвс тэжээлээ бэлтгэж базаах арга зүйн зөвлөгөөг тогтмолжуулж ажиллана.

4817144213
ЗЮА0039 9033475

# ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**6.1 "Шинэ зууны эхлэл-шилдэг сум Говь-Угтаал"**

6.1.1 Сумын төвийн тохижилт шинэчлэл хийх ажлын ТЭЗҮ хийлгэж, хатуу, хучилттай зам, явган зам, ногоон байгууламж, амарч зугаалах, ногоон зурвас байгуулна.

6.1.2 Сумын төвийн шугам сүлжээ /эвэр, бохир усны шугам/ цэвэрлэх байгууламж шинээр барина.

6.1.3 Сумын төвд 36 айлын орон сууцыг төр, хувийн хэвшилийн оролцоотойгоор барина.

6.1.4 Сумын төвийн цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг 10/0.4Кв-ын 400Ква КТПН 10кВ-ын ЦДАШ барьж нэмэгдүүлнэ.

6.1.5 Цагаандэлгэр-Говь-Угтаал сумын ЦДАШ-ыг төмөр бетон суурьтай, сиб кабелийн шугам болгож сумын төвийг цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэнэ.

6.1.6 Сумын нийтийн биеийн тамир спортын залыг барилгын ажлыг дуусгаж ашиглалтанд оруулна.

6.1.7 Сумын ахмадын өргөөний барилгыг стандартад нийцүүлэн барьж байгуулна.

6.1.8 Сумын төвийн төвлөрсөн халаалтын шугамыг орон нутгийн өмчид авч, өргөтгөн айл, өрх, аж ахуйн нэгжийг нэгдсэн халаалтын системд холбох ажлыг хийнэ.

6.1.9 Сумын төвийн хүлэмжийн аж ахуй байгуулахаар төлөвлөгдсөн хашааг сэргээн засварлаж, цахилгааны шугамыг түшиглэн гидропоник тариалалтын загвар лабортори барина.

6.1.10 Сумын төвийн барилга байгууламжууд, нийтийн орон сууцны барилгуудад их засвар хийнэ.

6.1.11 Инжнерийн хийцтэй гүн өрмийн худаг барьж байгуулна.

6.1.12 Шинэ гудамж төсөл хэрэгжүүлж, сумын төвийг бүхэлд нь өндөр хүчин чадал бүхий камертай болгоно.

6.1.13 Соёл спортын цогцолборын техник, аппартур, тоног төхөөрөмжийг шинэчилэн, лед дэлгэцтэй болгоно.

6.1.14 Сумын төвийн төв талбай сэргээн засварлана.

6.1.15 Сумын Гандан хийдийг сэргээн, засварлаж, орчин үеийн шийдлээр тохижуулна.

6.1.16 Сумын нийтийн биеийн тамирын гадна талбайг шинэчилэн тохижуулна.

4817144213
ЗЮА0039 9033475

106

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/166

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Гурвансайхан сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгаа гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Гурвансайхан сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Гурвансайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Гурвансайхан сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ..................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................/Б.ГАНТУЯА/

Гурвансайхан сумын Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгчдийн
2024 оны 06 сарын 23-ны өдрийн 01 тоот тогтоолын хавсралт

# 2024 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ГУРВАНСАЙХАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

БҮСЭЭ ДАГАЖ -СУМЫН ХӨГЖИЛ

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого""Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "БҮСЭЭ ДАГАЖ -СУМЫН ХӨГЖИЛ" мөрийн хөтөлбөрийг 6 үндсэн бүлэг, 20 дэд бүлэг, 105 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц
1.2 Эрүүл иргэн
1.3 Боловсролтой иргэн
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого
- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Гэр бүл
- Ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5 Хөдөлмөр эрхлэлт
1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
1.7 Эрүүл идэвхитэй амьдралтай иргэн

## ХОЁР. ХӨДӨӨ АЖУЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

## ГУРАВ. ХУВИЙН ХЭВШИЛ БА АЖЛЫН БАЙР

3.1 Шинэ ажлын байр
3.2 Төрөлжсөн аялал жуулчлал

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

## ТАВ. ХҮНААМ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

5.1 Тэрбум мод хөтөлбөр
5.2 Уламжлалт нүүдлийн аж ахуй

## ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

6.1 Сумын хөгжил

4817144213
ЗЮА0039 9033475

# 1 НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц*

1.1.1 ОНХС хөрөнгөөр төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц барих, төрийн албан хаагч, залуу гэр бүлийг нэн түрүүнд хамруулна.

1.1.2 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, хувь компаниудыг дэмжин хамтран ажиллана.

### *1.2 Эрүүл иргэн*

1.2.1 Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн хийх, эрүүл, зөв хооллолтыг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.2 Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг шинээр барина

1.2.3 “Элэг бүтэн Монгол”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” болон хүүхдийн “Эрүүл шүд” хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, үргэлжлүүлнэ.

1.2.4 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, “Эрт илрүүлэг” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.5 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтнуудыг жил бүр шалгаруулж, эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн*

1.3.1 Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн, холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, томилно.

1.3.2 Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж, сургалт, үйл ажиллагаанд хамруулна.

1.3.3 Сургуульд байгалийн ухааны кабинэт шинээр байгуулна.

1.3.4 Сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилтнуудыг жил бүр шалгаруулж, боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.5 Залуу багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хуучин дотуур байрыг багш, ажилчдын орон сууц болгоно.

1.3.6 Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

1.3.7 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

1.3.8 Багшийн хүрэлцээгүй, дутагдалтай байгаа багш нарт орон нутгийн нэмэгдэл олгохыг шийдвэрлэнэ.

1.3.9 Цахим сургууль болох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

4.2 Сэргээгдэх эрчим хүчний төслийг дэмжиж ажиллана

4.3 Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл, ухаалаг хэрэглээг нэвтрүүлж, ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлнэ.

4817144213
ЗЮА0039 9033475

ДЭРЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

МОНГОЛ АРДЫН НАМЫН АНХАН ШАТНЫ ХОРОО
07
ДУНДГОВЬ АЙМАГ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/171

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС
СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Луус сумын “Монгол ардын нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Луус сумын “Монгол ардын нам”-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Луус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Луус сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ...... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................../Б.ГАНТУЯА/

Луус сумын Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгчдийн
2024 оны 06 сарын 23 -ны өдрийн 24/01 тоот тогтоолын хавсралт.

# 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## ЛУУС НУТГИЙН СЭРГЭЛТ

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого""Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "ЛУУС НУТГИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийг 6 үндсэн бүлэг, 76 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

1.1 Эрүүл иргэн
1.2 Боловсролтой иргэн
1.3 Орон сууц
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн бодлого
1.5 Малчдын талаар авч хэрэгжүүлэх бодлого

## ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

## ГУРАВ. БИЗНЕС, ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

## ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭЭМЖИЙН БОДЛОГО

## ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

ЗЮА0039 0023475

# 1 НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

## *1.1 Эрүүл иргэн*

1.1.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, цахим шинжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлэгт иргэн бүрийг хамруулна.

1.1.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

1.1.3 Эмч, сувилагч, эмнэлэгийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэхэд дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

1.1.4 Эмнэлгийн авто машиныг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар стандартад нийцүүлж шинэчлэнэ.

1.1.5 “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг зорилтод бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.1.6 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

## *1.2 Боловсролтой иргэн*

1.2.1 ЕБСургуулийн суралцагч бүрт англи хэлийг эзэмших тэгш боломж бүрдүүлж, англи хэлний багшийг гадаадад мэргэжил дээшлүүлнэ.

1.2.2 ЕБСургуульд байгалийн ухаан, технологийн хичээлийн туршилтын талбай байгуулна.

1.2.3 Төгсөөд ирж байгаа залуу багш нарт зориулсан орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ.

1.2.4 “Багшийн хөгжлийн төв”-ийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.5 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.2.6 Ахмад багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санг байгуулна.

## *1.3 Орон сууц*

1.3.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.2 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.3.3 “ 1000 айлын орон сууц” хөтөлбөрийг хүрээнд 12-с доошгүй айлын орон сууц барина

## *1.4Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн бодлого*

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.2 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.4.3 Цэцэрлэг, сургуулийн орчны камержуулын хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.4.4 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

3ЮА0039 9033475

1.4.5 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.6 Айл өрхийн амьжиргааны түвшинг олон улсын аргачлалаар тогтоож, ажил орлоготой болгох, малжуулах, туслах аж ахуй эрхлэх зэргээр орлогын өсөлтийг дэмжих бодитой арга хэмжээг авч ажиллана.

1.4.7 Сувилалд явж чаддаггүй ахмадуудыг орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлнэ.

1.4.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.9 Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах бодлого баримтлана.

1.4.10 Хүнсний нөөц нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулахад чиглэсэн аж ахуй эрхлэх, шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлагыг санхүү, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.4.11 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.12 Өөрийн нөөц бололцоогоо дайчлан сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн дунд "Оны шилдэг бүтээгдэхүүн" номинацаар шалгаруулна.

1.4.13 Аймаг, аймгийн бүсийн аварга шалгаруулах үндэсний болон бусад спортын уралдаан тэмцээнийг 1-2 удаа зохион байгуулна.

## 1.5 МАЛЧДЫН СЭРГЭЛТ

1.5.1 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.

1.5.2 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

1.5.3 Сумын хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.

1.5.4 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

1.5.5 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.5.6 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.5.7 Эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр хангаж, Старлинкийн интернетэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.

1.5.8 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, сумын хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

1.5.9 Сумын мал эмнэлгийн тасгийг бүрэн орон тоогоор ажиллуулж мэргэжлийн залуу боловсон хүчнийг амьдрах орчин нөхцөлөөр дэмжиж, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтлана. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

1.5.10 Сумын мал сүрэг голомтлон гардаг хонь, ямааны шөвөг яр өвчний үйлчилгээний хөлсийг орон нутгийг хөгжүүлэх сангаас олгоно.

## ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.
2.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог төрийн дэмжлэгтэй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулж шинэчлэн байгуулна
2.3 Сумандаа махны чиглэлээр хонь, үхрээ сайжруулах малчдын санаачлагыг дэмжинэ.
2.4 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх хоршоог байгуулна.
2.5 Шинээр малчин болсон залуу гэр бүлийг татварын бодлогоор дэмжинэ.
2.6 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.
2.7 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийг шинээр барих замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, сумын хэрэгцээг хангана.
2.8 Иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
2.9 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. БИЗНЕС, ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

3.1 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдаа болон “Дундговь түншлэл” арга хэмжээнд зохион байгуулалттайгаар оролцуулж, үндэсний үйлдвэрлэгч нараа сурталчилна.
3.2 “Луус түншлэл” арга хэмжээг жил бүр зохион байгуулна.
3.3 “Сум хөгжүүлэх сан”-гийн зээлийг ажлын байр нэмэгдүүлэх жижиг дунд бизнест тэргүүн ээлжинд олгоно.
3.4 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
3.5 Ажлын байрыг шинээр бий болгосон орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
3.6 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхлэгчийг иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

## ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭЭМЖИЙН БОДЛОГО

4.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
4.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
4.3 Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.
4.4 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
4.5 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

17144213
ЗЮА0039 0023475

7

4.6 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.
4.7 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж, камерын хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
4.8 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

## ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

5.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.
5.2 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.
5.3 Амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг хүүхэд залуучуудад хэвшүүлнэ.
5.4 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд албан байгууллага, айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих хөдөлгөөн өрнүүлж ургуулсан модны тоотой уялдуулан дэмжлэг үзүүлнэ.
5.5 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.
5.6 Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.
5.7 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.
5.8 Сумын төвийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усаар хангах, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулна.
5.9 Сумын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулж, эрүүл цэвэр орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

6.1 Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Сумын төвийн шинэчлэл” төслийг ажлын үргэлжлүүлж дуусгана.
6.2 Төрийн албан хаагчдын 12-24 айлын орон сууц барьна.
6.3 Сумын төвийн Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барьна.
6.4 Сумын төвийн Нутгийн удирдлагын барилга шинээр барьна.
6.5 Сумын төвийн дэргэд 3 километрээс багагүй урттай ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн бий болгож, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
6.6 Шаардлага хангасан халуун усны тогтмол үйлчилгээг бий болгоно.

ЗЮА0039 9033475

5

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/169

танай ________ -ны № ________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Өлзийт сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Өлзийт сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Өлзийт сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ....... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................./Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ..................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................./Б.ГАНТУЯА/

# 2024 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ

"Алсын харaa-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого""Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 19 дэд бүлэг, 189 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

### НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц
1.2 Эрүүл иргэн
1.3 Боловсролтой иргэн
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого

- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Гэр бүл
- Ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5 Хөдөлмөр эрхлэлт
1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
1.7 Эрүүл идэвхитэй амьдралтай иргэн

### ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

### ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин
3.2 Шинэ ажлын байр
3.3 Төрөлжсөн аялал жуулчлал

### ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

### ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

5.1 Тэрбум мод хөтөлбөр
5.2 Уламжлалт нүүдлийн аж ахуй
5.3 Үнэт баялаг ус

### ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

6.1 Бүтээн байгуулалт

6.2 Сумын хөгжил

# 1 НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц-нутгийн сэргэлт*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1.2 Төрийн албан хаагчдыг түрээсийн орон сууцанд хамруулна.

1.1.3 15-20 айлын орон сууц барина

### *1.2 Эрүүл иргэн-нутгийн сэргэлт*

1.2.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.2.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

1.2.3 Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод сургах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.4 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.5 “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

1.2.6 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж “Эрт илрүүлэг” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.7 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн-нутгийн сэргэлт*

1.3.1 Сургууль цэцэрлэгийн багш нарыг дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлж туршлага судлуулна.

1.3.2 Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.3.3 Төгсөөд ажиллаж байгаа залуу багш нарт зориулсан түрээсийн орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ.

1.3.4 “Багшийн хөгжлийн төв”-ийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.5 “Байгалийн ухаан” болон “Математик”, “Англи хэл”, “Оюунлаг Дундговь” дэд хөтөлбөрүүдийн хүрээнд улс, бүсийн хэмжээний төрөлжсөн олимпиадыг тогтмол зохион байгуулна.

1.3.6 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.7 “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүсүүдийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан ур чадвартай гагнуурчин, инженер техникийн мэргэжилтнийг гадаад, дотоодод бэлтгэх бодлого баримтална.

1.3.8 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

### *1.4Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого*

**Хүүхэд-нутгийн сэргэлт**

4817144213
ЗЮА0039 903475

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулна.

1.4.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.4.5 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.4.6 .Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

**Оюутан, залуучууд-нутгийн сэргэлт**

1.4.7 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

1.4.8 Хөдөлмөрийн хуулинд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж шинэ ажлын байр бий болгох бодлого баримтална.

1.4.9 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.4.10 Төгсөгчдөд зориулан "Хийнгээ сурья- Орлого олъё-Хэмнэе" загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.

**Гэр бүл-нутгийн сэргэлт**

1.4.11 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.12 Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй тогтолцоог хөгжүүлнэ.

1.4.13 Айл өрхийн амьжиргааны түвшинг олон улсын аргачлалаар тогтоож, ажил орлоготой болгох, малжуулах, туслах аж ахуй эрхлэх зэргээр орлогын өсөлтийг дэмжих бодитой арга хэмжээг авч ажиллана.

**Ахмад настан – нутгийн сэргэлт**

1.4.14 Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ

1.4.15 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.16 Сумандаа ахмадын сувилал байгуулж амралт сувилалд явж чаддагүй ахмадуудыг орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлнэ.

1.4.17 Ахмадуудын урлаг, спортын наадмыг сумандаа бүсчилэн зохион байгуулна.

1.4.18 Улаанбаатар хотод оношлогооны төвд 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар хамруулж, зардлыг нь эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.

1.4.19 Ахмад настнуудад өдрийн болон 7 хоногийн эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх чийрэгжүүлэлтийн төв байгуулна.

**Малчид-нутгийн сэргэлт**

***Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:***

1.4.20 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.

1.4.21 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
1.4.22 Говийн бүсийн хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.
1.4.23 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.
1.4.24 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.
1.4.25 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
1.4.26 Эмнэлгийг Старлинкийн интернетэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.
1.4.27 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, сумын хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

1.4.28 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.
1.4.29 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

## 1.5 Хөдөлмөр эрхлэлт-нутгийн сэргэлт

1.5.1 Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах бодлого баримтлана.
1.5.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
1.5.3 Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
1.5.4 Хүнсний нөөц нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулахад чиглэсэн аж ахуй эрхлэх, шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлагыг санхүү, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.
1.5.5 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
1.5.6 Өөрийн нөөц бололцоогоо дайчлан сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг дэмжиж жил бүр "шилдэг бүтээгдэхүүн" шалгаруулна

## *1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн-нутгийн сэргэлт*

1.6.1 "Уртын дууч, морин хуурчдын"-III их наадмыг оролцоно
1.6.2 Жил бүр үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион бхйгуулна.
1.6.3 Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

## *1.7 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн-нутгийн сэргэлт*

1.7.1 Иргэд идэвхитэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуйн болон гүйлтийн зориулалтын зам талбайтай болно.
1.7.2 Өлзийт сумын ЕБС төгсөгчдийн "Бага Олимп" спортын наадмыг зохион байгуулна.
1.7.3 Аймаг, аймгийн бүсийн аварга шалгаруулах үндэсний болон олимпийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

4317144213
ЗІОА0030 0000175

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 2.1 "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл"-нутгийн сэргэлт

2.1.1 .Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.

2.1.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог төрийн дэмжлэгтэй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулж шинэчлэн байгуулна

2.1.3 Дэлийн улаан ямаа гойд ашиг шимт цөм сүргийг бий болгоно.

2.1.4 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх хоршооллыг бүсчлэн байгуулах ажлыг дэмжинэ

2.1.5 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.

2.1.6 Малчидын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.1.7 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.

2.1.8 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.1.9 Мах, сүү, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулж, дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.

2.1.10 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 3.1 Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин-нутгийн сэргэлт

3.1.1 Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.

3.1.2 Суманд жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан бизнес инкубатор төв байгуулна.

3.1.3 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, болон дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдаа болон "Дундговь түншлэл" арга хэмжээнд жил бүр оролцож үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин, сурталчилна.

3.1.4 Гадаад,дотоодын хөрөнгө оруулагчдын "Discover Dundgovi" зөвлөгөөнд оролцож орон нутагт хөрөнгө оруулалтыг татна.

### 3.2 Шинэ ажлын байр-нутгийн сэргэлт

3.2.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

3.2.2 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

3.2.3 Ажлын байрыг шинээр бий болгосон бүс, орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.

ЗЮА0039 9033475

3.2.4 Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.5 Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлогоор дэмжинэ.

3.2.6 Нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

3.2.7 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

***3.3 төрөлжсөн аялал жуулчлал – нутгийн сэргэлт***

3.3.1 “GoMongolia” хөтөлбөрийн хүрээнд суманд зочлох гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.3.2 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.

3.3.3 Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.3.4 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /Айрагны баяр, тэмээний баяр, ардын урлагын наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна.

3.3.5 Цагаан суварга, дэл уул, өөш манхан, морин толгойн цав зэрэг аялал жуулчлалын төвийг байгуулж орон нутгийн аялал жуулчлалын сүлжээг олон улсын аялалын бүстэй холбоно.

3.3.6 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.7 Аялал жуулчлалын гадаадад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа маркенгийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.3.8 Цагаан суварга байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрыг түшиглэсэн, аялал жуулчлалын цогцолбор байгуулна.

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

### 3.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа - нутгийн сэргэлт

3.4.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

3.4.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

3.4.3 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

3.4.4 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

3.4.5 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

3.4.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ..

3.4.7 Суманд дутагдалтай байгаа боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор оюутнуудад бүрэн тэтгэлэг олгоно.

3.4.8 Тогтвор суурьшилтай ажиллах төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж дэмжлэг үзүүлнэ.

### 3.5 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ – нутгийн сэргэлт

3.5.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.5.2 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

3.5.3 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

3.5.4 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгох.

ЗЮА0039 9033475

# ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

## 3.6 “Тэрбум мод” хөтөлбөр – нутгийн сэргэлт

3.6.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

3.6.2 Монгол орны ус цаг уурын орчны шинжилгээний салбарт өндөр технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн техникийн шинэчлэл хийж, цаг уур, гамшгийг эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана.

3.6.3 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

3.6.4 Ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

3.6.5 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоотой уялдуулна.

3.6.6 Суманд нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн мод тарих идэвх сонирхлыг нэмэгдүүлнэ. Үүнд: гэр бүл бологсдын, төгсөлтийн, алдар цолтны, бурхан бологсдын гэх мэт

## 3.7 Уламжлалт нүүдлийн аж ахуй – нутгийн сэргэлт

3.7.1 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

3.7.2 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

3.7.3 Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

3.7.4 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

## 3.8 Үнэт баялаг ус – нутгийн сэргэлт

3.8.1 Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8.2 Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.

3.8.3 Уул уурхайд үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.

# ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**6.1 Бүтээн байгуулалт – нутгийн сэргэлт**

6.1.1 Байгаль, газарзүйн онцлогт түшиглэн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

6.1.2 Говийн бүсийн нар, салхины нөөцийг ашиглан, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний станцуудыг байгуулна.

6.1.3 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ

6.1.4 Сумын төвын 0.4квт-ын агаарын шугамыг шинэчлэх

6.1.5 Гэр хорооллын инженерийн дэд бүтцэд холбох

6.1.6 Жишиг гудамж байгуулна

6.1.7 Онцгой байдлын эрэн хайх аврах анги байгуулна

6.1.8 Цаг уурын өртөө байгуулна

6.1.9 Сумын төвийн айл өрхүүд нүхэн жорлонгоо эко жорлон болгох ажлыг төр иргэд хамтран хэрэгжүүлнэ

6.1.10 Сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийг шинээр барьна.

6.1.11 Сумданд ахмадын өргөө байгуулна.

6.1.12 Сумын сургуулийн үкийн цай номын сангийн барилгын өргөтгөл,спорт залны барилгыг засварт оруулна.

6.1.13 Сумын төвийн дэргэд ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн бий болгож, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

25

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/168

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Өндөршил сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгаа гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Өндөршил сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Өндөршил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Өндөршил сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ....... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................/Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ..................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................./Б.ГАНТУЯА/

27

Дундговь аймгийн Өндөршил сумын
Монгол Ардын Намын хорооны
2024 оны 6 сарын 13-ний өдрийн
хурлаар батлав.

# СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖИЛ- ӨНДӨРШИЛИЙН СЭРГЭЛТ

"Алсын харааа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", "Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖИЛ- ӨНДӨРШИЛИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийн хүрээнд 5 үндсэн бүлэг, 12 дэд бүлэг, 82 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг өнөөгийн түвшнээс 5 дахин нэмэгдүүлнэ.

1.1.2 "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмадуудыг нэн түрүүнд хамруулна.

1.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ

1.1.4 "Орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 24 айлын тохилог орон сууцыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжин шинээр барина.

### *1.2 Эрүүл иргэн*

1.2.1 Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтнуудыг гадаад, дотоодод сургах бодлого хэрэгжүүлнэ

1.2.2 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.3 "Элэг бүтэн Монгол", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" болон хүүхдийн "Эрүүл шүд" "Хавдрын эсрэг -хамтдаа" дэд хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, үргэлжлүүлнэ.

ЗЮА0039 9023475

1.2.4 "Эрт илрүүлэг" хөтөлбөрийн дагуу иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.2.5 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтнуудыг жил бүр шалгаруулж, эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

***1.3 Боловсролтой иргэн***

1.3.1 Аймгийн Политехник коллежитой нягт хамтран ажиллаж, хүүхэд залуучуудаа говийн бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн сурахад дэмжиж ажиллана.

1.3.2 Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, ЕБС, СӨБ-ын байгууллагын багш нарыг гадаад, дотоодод сургаж, бэлтгэх бодлого баримтална.

1.3.3 Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж, сургалт, үйл ажиллагаанд хамруулна.

1.3.4 Бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдад англи хэл эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, англи хэлний багш нарыг гадаадад сургаж чадавхжуулна.

1.3.5 Цэцэрлэг, сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.3.6 Сургуульд байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбайг байгуулна.

1.3.7 Сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилтнуудыг жил бүр шалгаруулж, боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.8 Залуу багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.9 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

***1.3.Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого***

**Хүүхэд**

1.3.10 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан, ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.3.11 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулна.

1.3.12 Боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй, эрсдэлт бүлгийн суралцагчдад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.3.13 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээлтэй, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

4817144213 ...3475

**Оюутан, залуучууд**

1.3.14 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

1.3.15 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

**Ахмад настан**

1.3.16 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.17 Ахмадуудын урлаг, спортын наадмыг аймагтаа бүсчилэн зохион байгуулна.

**Малчид**

Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:

1.3.18 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.19 Малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.

1.3.20 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

1.3.21 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулахыг бодлогоор дэмжинэ.

1.3.22 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.23 Зудын эрсдэлийг даван туулах "ӨВӨЛЖӨӨ" төсөл хэрэгжүүлнэ.

1.3.24 Эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр ханган, Старлинкийн интернетэд холбон малчдад алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.

1.3.25 Малчдын эрүүл мэндийн суурь асуудал болох ундны усыг стандартын түвшинд хүргэж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

1.3.26 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, сумын хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

***1.4 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн***

1.4.1 Соёл, урлагийн ажилтнуудын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулж, жил бүр шилдэг ажилтнуудыг шалгаруулан, гадаад, дотоодын арга хэмжээнд оролцуулж, туршлага судлуулна.

1.4.2 Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

4817144213
ЭА0039 9033475

1.4.3 Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

***1.5 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн***

1.5.1 Иргэдийн идэвхитэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуйн зориулалтын зам байгуулна.

1.5.2 Сумын хэмжээнд "Бага Олимп" спортын наадамд 2 жил тутамд зохион байгуулалтайгаар оролцож, өмнөх амжилтаа ахиулна.

1.5.3 Сумын аварга шалгаруулах үндэсний болон олимпийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулна.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ, ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

***2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл***

2.1.1 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, сум дундын хоршоог бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.

2.1.2 Стандартын шаардлага хангасан өвс, тэжээлийн агуулах шинээр барьж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.3 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, иргэдийн хэрэгцээг хангана.

2.1.4 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж, уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.1.5 Мах, сүү, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулж, дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.

2.1.6 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, болон дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдаа болон "Дундговь түншлэл" арга хэмжээнд жил бүр оролцож, үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин, сурталчилна.

2.1.7 Хөрөнгө оруулагчдын зөвлөгөөнийг хоёр жил тутамд зохион байгуулж, орон нутагт хөрөнгө оруулалтыг татна.

2.1.8 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

2.1.9 Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

2.1.10 Нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

2.1.11 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

4817144213

2.1.12 Орон нутгийн байгалийн баялаг, ашигт малтмалд түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулна.

**2.2 *Төрөлжсөн аялал жуулчлал***

2.2.1 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.

2.2.2 Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2.2.3 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /Айрагны баяр, тэмээний баяр, ардын урлагын наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна.

2.2.4 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

***3.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа***

3.1.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнтэй уялдуулан орон нутгийн нэмэгдлийг жил бүр 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.

3.1.2 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

3.1.3 Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж, шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

**3.2 *Иргэдэд ойр төрийн үйлчилгээ***

3.2.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.2.2 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгож, орон нутгийн ААН, иргэдийг оролцуулах.

## ДӨРӨВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

4.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

4.2 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

4.3 Ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

4.4 "Тэрбум" мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.

4.5 Нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн мод тарих идэвх сонирхлыг нэмэгдүүлнэ. Үүнд: гэр бүл бологсдын, төгсөлтийн, алдар цолтны, бурхан бологсдын гэх мэт

4.6 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

4.7 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

4.8 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

4.9 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

4.10 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

## ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

5.1 Төрийн албан хаагчдын 12-24 айлын орон сууц барина.

5.2 Сумын төвийн инженерийн шугам сүлжээ /Цэвэр, бохир усны шугам/ цэвэрлэх байгууламж шинээр барьж, сумын төвийн айл өрхийн амьдрах орчинг сайжруулна.

5.3 Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барина.

5.4 Соёл, спортын цогцолборын барилгыг ашиглалтад бүрэн оруулна.

5.5 Нутгийн удирдлагын барилга шинээр барина.

5.6 Ахмадын өргөө байгуулна.

5.7 Нийтийн биеийн тамирын цогцолбор зал, Нийтийн биеийн тамирын гадна талбайг хорооллуудад байгуулна.

5.8 Сумын төвийн хойд, баруун хойд талаар 1 километрээс багагүй урттай ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.9 Халуун усны тогтмол үйлчилгээг бий болгоно.

5.10 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

МОНГОЛ АРДЫН НАМЫН ... ШАТНЫ ХОРОО ДУНДГОВЬ АЙМАГ 11

4817144213
ЗҮА0039 9033475

87

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/176

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Сайнцагаан сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Сайнцагаан сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( .10.... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Сайнцагаан сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ...10.... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ........................./Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ........................./Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ...................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ...................../Б.ГАНТУЯА/

Сайнцагаан сумын Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгчдийн

2024 оны 06 сарын 20-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралт

# 2024 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ: "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого","Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийг 6 үндсэн бүлэг, 19 дэд бүлэг, 157 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц
1.2 Эрүүл иргэн
1.3 Боловсролтой иргэн
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого
- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Гэр бүл
- Ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5 Хөдөлмөр эрхлэлт
1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
1.7 Эрүүл идэвхитэй амьдралтай иргэн

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин
3.2 Шинэ ажлын байр
3.3 Төрөлжсөн аялал жуулчлал

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

## ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

5.1 Тэрбум мод хөтөлбөр
5.2 Уламжлалт нүүдлийн аж ахуй
5.3 Үнэт баялаг ус

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

6.1 Бүтээн байгуулалт

6.2 "Шинэ Мандалговь"

6.3 Сумын хөгжил

4817144213
SUA0039 9033475

# 1 НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг өнөөгийн түвшнээс 5 дахин нэмэгдүүлнэ.

1.1.2 “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмадуудыг нэн түрүүнд хамруулна.

1.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.1.4 “ 1000 айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /аймгийн төвд (Сайнцагаан) 700 айл, сумдад 300 айл/

### *1.2 Эрүүл иргэн*

1.2.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.2.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

1.2.3 Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод сургах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.4 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.5 “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

1.2.6 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж “Эрт илрүүлэг” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.7 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн*

1.3.1 Сайнцагаан сумын хэмжээнд цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгуудыг бүрэн шинэчилж дуусгана.

1.3.2 ОХУ-ын хөрөнгө оруулалттай олон улсын жишигт нийцсэн говийн бүсийн ЕБС-ийн сургууль байгуулна.

1.3.3 Говийн бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлнэ.

1.3.4 Бүх шатны сургалтын байгууллагын суралцагч англи хэлийг эзэмших тэгш боломж бүрдүүлж, англи хэлний багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлнэ.

1.3.5 Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.3.6 Төгсөөд ажиллаж байгаа залуу багш нарт зориулсан түрээсийн орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ.

1.3.7 Багшлах хүний нөөцийг чадавхжуулж СӨБ, ЕБС багшийг гадаад, дотоодод сургаж, бэлтгэх бодлого баримтална.

1.3.8 “Багшийн хөгжлийн төв”-ийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4817144213
ЗЮА0030 9003475

1.3.9 "Байгалийн ухаан" болон "Математик", "Англи хэл", "Оюунлаг Дундговь" дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, улс, бүсийн хэмжээний төрөлжсөн олимпиадыг аймагтаа тогтмол зохион байгуулна.

1.3.10 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.11 "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүсүүдийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан ур чадвартай гагнуурчин, инженер техникийн мэргэжилтнийг гадаад, дотоодод бэлтгэх бодлого баримтална.

1.3.12 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

1.3.13 Багшийн хүрэлцээгүй сумдуудад цахимаар ажиллах нөхцлийг бүрдүүлж, багш нарыг давхар ажиллаж, цалин орлогоо нэмэгдүүлэх боломжтой болгоно.

1.3.14 Ахмад багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санг сургууль бүрийн дэргэд байгуулна.

## *1.4Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого*

### Хүүхэд

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулна.

1.4.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.4.5 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.4.6 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

### Оюутан, залуучууд

1.4.7 Оюутны цагаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журмыг сайжруулж нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх, цагийн ажлын зуучлалыг E-Student цэсээр дамжуулна.

1.4.8 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

1.4.9 Хөдөлмөрийн хуулинд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж шинэ ажлын байр бий болгох бодлого баримтална.

1.4.10 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.4.11 Төгсөгчдөд зориулан "Хийнгээ сурья- Орлого олъё-Хэмнэе" загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.

1.4.12 Сайнцагаан сумын Залуучуудын хөгжлийн төв байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

### Гэр бүл

1.4.13 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.14 Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй тогтолцоог хөгжүүлнэ.

1.4.15 Цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийг уртасгаж эцэг, эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.16 Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.
1.4.17 Айл өрхийн амьжиргааны түвшинг олон улсын аргачлалаар тогтоож, ажил орлоготой болгох, малжуулах, туслах аж ахуй эрхлэх зэргээр орлогын өсөлтийг дэмжих бодитой арга хэмжээг авч ажиллана.

**Ахмад настан**

1.4.18 Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, геронтологийн салбарыг бодлогоор хөгжүүлнэ.
1.4.19 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
1.4.20 Аймагт ахмадын сувилал байгуулж амралт сувилалд явж чаддагүй ахмадуудыг орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлнэ.
1.4.21 Түрээсийн орон сууцны хороолол байгуулж, ахмадуудаа хамруулан, төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэнэ.
1.4.22 Говийн бүсийн асрамжийн газрыг аймагтаа байгуулж, харж хандах хүнгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамжийн үйлчилгээ үзүүлнэ.
1.4.23 Ахмадуудын урлаг, спортын наадмыг аймагтаа бүсчилэн зохион байгуулна.
1.4.24 Улаанбаатар хотод орчин цагын шинэ тоног төхөөрөмжтэй оношлогооны төвд 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар хамруулж, зардлыг нь эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.
1.4.25 Сумын багийн ахмадын хөгжлийн төвийг барих үе шаттайгаар хөгжүүлэх.
1.4.26 Ахмад настнуудад өдрийн болон 7 хоногийн эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх геронтологийн төв байгуулна.

**Малчид**

***Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:***

1.4.27 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.
1.4.28 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
1.4.29 Говийн бүсийн хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.
1.4.30 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.
1.4.31 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.
1.4.32 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
1.4.33 Зудын эрсдэлийг даван туулах "ӨВӨЛЖӨӨ" төсөл хэрэгжүүлнэ.
1.4.34 Бүх сумдын эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр хангаж, Старлинкийн интернэтэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.
1.4.35 Малчдын эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох ундны усыг стандартын түвшинд хүргэж, хэрэглээнд нэвтрүүлнэ.
1.4.36 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, аймгийн хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

1.4.37 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

4817144213
ЗЮА0039 9033475

1.4.38 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асрамжийн төвийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжинэ.
1.4.39 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
1.4.40 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

## 1.5 Хөдөлмөр эрхлэлт

1.5.1 Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах бодлого баримтлана.
1.5.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
1.5.3 Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
1.5.4 Хүнсний нөөц нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулахад чиглэсэн аж ахуй эрхлэх, шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлагыг санхүү, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.
1.5.5 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
1.5.6 Өөрийн нөөц бололцоогоо дайчлан аймгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийг 10-аас доошгүй номинацаар шалгаруулж "Оны шилдэг бүтээгдэхүүн" ном хэвлүүлж үйл ажиллагааг нь сурталчилна.

## *1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн*

1.6.1 "Уртын дууч, морин хуурчдын"-III их наадмыг зохион байгуулахад хамтран дэмжиж ажиллана.
1.6.2 Жил бүр соёл, урлагийн шилдэг ажилчдыг шалгаруулж гадаад, дотоодын арга хэмжээнд туршлага судлуулах, нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.
1.6.3 Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулахыг дэмжин ажиллана.

## *1.7 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн*

1.7.1 Мандалговь хотод усан бассейн бүхий спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.
1.7.2 Иргэд идэвхитэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуйн зориулалтын зам талбайтай болно.
1.7.3 Сумын "Бага Олимп" спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.
1.7.4 Улс бүсийн аварга шалгаруулах үндэсний болон олимпийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

# ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

## 2.1 "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл"

2.1.1 Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.
2.1.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог төрийн дэмжлэгтэй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулж шинэчлэн байгуулна
2.1.3 Сумандаа говийн бүсийн гойд ашиг шимт цөм сүргийг бий болгоно.
2.1.4 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.
2.1.5 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.
2.1.6 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.
2.1.7 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.

4817144213
ЗЮА0039 9003475

2.1.8 Сайнцагаан сумандаа стандартын өвс, тэжээлийн агуулах нөөцийг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.9 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, аймгийн хэрэгцээг хангана.

2.1.10 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.1.11 Мах, сүү, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулж, дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.

2.1.12 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

2.1.13 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 3.1 Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин

3.1.1 Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.

3.1.2 Мандалговь хотод жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан бизнес инкубатор төв байгуулна.

3.1.3 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, болон дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдаа болон “Сайнцагаан сумын түншлэл” арга хэмжээг жил бүр зохион байгуулж үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин, сурталчилна.

3.1.4 БНХАУ, ОХУ, Өмнөд Солонгос, Япон, Чех зэрэг улс орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлж, шинээр боломжит улс орнуудтай харилцаа тогтооно.

### 3.2 Шинэ ажлын байр

3.2.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

3.2.2 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

3.2.3 Ажлын байрыг шинээр бий болгосон бүс, орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.

3.2.4 Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.5 Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлогоор дэмжинэ.

3.2.6 “Пассив” хаусын үйлдвэрийг хөгжүүлнэ.

3.2.7 Сайнцагаан сумын хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

3.2.8 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

3.2.9 Орон нутгийн байгалийн баялаг, ашигт малтмалд түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулна.

### *3.3 төрөлжсөн аялал жуулчлал*

3.3.1 Суманд зочлох гадаад, дотоодын жуулчдын аялах тав тухтай орчин бүрдүүлэх.

3.3.2 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.

ЗЮА0039 9093475

3.3.3 Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.3.4 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /Айрагны баяр, тэмээний баяр, ардын урлагын наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна.

3.3.5 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.6 Аялал жуулчлалын гадаадад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа маркенгийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.3.7 Сумдын орох гарах хаалга, олон нийтийн худалдаа үйлчилгээний төвүүдэд түшиглэн, ариун цэврийн байгууламж бүхий нийтийн бие засах газруудыг бий болгоно.

4811144213
ЗЮА0039 9033475

## 3.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

3.4.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

3.4.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

3.4.3 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

3.4.4 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

3.4.5 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

3.4.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

## 3.5 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

3.5.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.5.2 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

3.5.3 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

3.5.4 “Мандалговь хот”-ын удирдлагын төвийг бий болгоно.

3.5.5 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгох.

4817144213
ЗЮА0030 9003475

## 3.6 "Тэрбум мод" хөтөлбөр

3.6.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

3.6.2 Монгол орны ус цаг уурын орчны шинжилгээний салбарт өндөр технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн техникийн шинэчлэл хийж, цаг уур, гамшгийг эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана.

3.6.3 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

3.6.4 Ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

3.6.5 "Тэрбум" мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.

3.6.6 Сумын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн мод тарих идэвх сонирхлыг нэмэгдүүлнэ. Үүнд: гэр бүл бологсдын, төгсөлтийн, алдар цолтны, бурхан бологсдын гэх мэт

## 3.7 Уламжлалт нүүдлийн аж ахуй

3.7.1 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

3.7.2 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.7.3 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

3.7.4 Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

3.7.5 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

3.7.6 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

## 3.8 Үнэт баялаг ус

3.8.1 Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8.2 Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.

3.8.3 Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг үйлдвэр, уул уурхайг дэмжинэ.

3.8.4 Уул уурхайд үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.

3.8.5 Суманд хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усны хайгуул судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлнэ.

4817144213
ЗЮА0039 0033475

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 6.1 Бүтээн байгуулалт

6.1.1 Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх тохиромжтой дөрвөн байршлыг санал болгож, хүсэлт гаргасан хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

6.1.2 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.

6.1.3 Мандалговь хотод хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр шинээр барьж, сумдын хог хаягдалын менежментийг сайжруулна.

### 6.2 “Шинэ Мандалговь”

6.2.1 Мандалговь шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж /0,6кВ болон 0,4кВийн хувиарлах сүлжээ/-р бүрэн хангана.

6.2.2 Бохир зайлуулах шугам сүлжээг өргөтгөнө.

6.2.3 Хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлж, А бүсийн шороон зам, гарцуудыг 100 хувь засмал зам болгож тоосжилтыг багасгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

6.2.4 “Өндөр ээж” төвийн уулзвараас ШШГГазар, Баруун цагаан дэлгүүр, Хуучин наадмын талбай хүртэлх босоо тэнхлэгийн 3.9 км хатуу хучилттай авто зам шинээр барих.

6.2.5 Борооны ус тогтдог автозамуудын ус зайлуулах шугамыг бүрэн шинэчилнэ.

6.2.6 Одоо ашиглагдаж байгаа хатуу хучилттай автозамуудыг дахин шинээр хучих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

6.2.7 Гэр хорооллын инжнерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

6.2.8 “Шинэ гудамж”, “Шинэ хороолол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.2.9 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон, хаус/ орон сууцны хангамжыг нэмэгдүүлж, инжнерийн хангамжтай сууцаар хангана.

6.2.10 Хуучин ашиглалтгүй болсон барилгуудыг буулгаж, орчин үеийн шинэ барилга барих хувийн хэвшлийг дэмжинэ.

6.2.11 Мандалговь хотын айл өрхийн нүхэн жорлонг эко 00 болгоно.

### 6.3 “Сумын хөгжил” – нутгийн сэргэлт

6.3.1 Сайнцагаан 9,10-р хүүхдийн цэцэрлэг шинээр барьна.

6.3.2 Сумдад нийтийн биеийн тамирын цогцолбор зал, гадна талбайг бий болгож ашиглалтанд оруулна.

6.3.3 Сумын төвүүдийн дэргэд 3 километрээс багагүй урттай ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн бий болгож, иргэдийн амарч зугаалах , чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

6.3.4 Сумын хөдөөгийн бүх багуудыг үүрийн телефоны компиантай хамтран ажиллах.

4817144213
ЗЮА0039 9033475

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/173

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Сайхан-Овоо сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Сайхан-Овоо сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн

140

мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайхан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ....... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ....................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ....................../Б.ГАНТУЯА/

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын
Монгол Ардын Намын хорооны
02 дугаар тогтоолын хавсралт

# 2024 ОНЫ САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ САЙХАН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ХӨНДӨЛГҮЙ ХӨГЖИНӨ
УХАЛГҮЙ УРАГШИЛНА.

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", "Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан орон нутгийнхаа нийт иргэдийн саналд тулгуурлан уул уурхайгүй, уламжлалт хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг хөгжүүлж, иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 46 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## 1. Хүний хөгжил, өрхийн сэргэлт

1.1. "Амар амгалан гэр бүл" багц сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2. "Шинэ үеийн Малчин" сумын малчдын уулзалт зөвлөгөөнийг 2 жилд 1 удаа зохион байгуулна.

1.3. Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэнэ.

1.4. Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг дэмжин чуулга уулзалтыг 2 жилд 1 удаа зохион байгуулна.

1.5. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.6. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцлийг нэмэгдүүлнэ.

1.7. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлах мэдээллээр хангах, хөнгөлөлттэй зээлд хамруулах.

1.8. Орон нутагт төрийн албаны орон тоо дутагдалтай байгаа нөхцөл байдалд онцгой анхаарал хандуулж тэднийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах ажлыг бодлогоор дэмжиж ажиллах, нутгийн залуу боловсон хүчнийг бэлтгэх, ажлын байраар хангах.

## 2. Сумын эдийн засгийг өсгөх, хөдөө аж ахуйн салбарын сэргэлт

2.1. Орон нутгийн төсвийн орлого, зарцуулалтанд тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлж иргэдэд ил тод мэдээлнэ.

2.2. Татварын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, сумын төсвийн орлогыг нэмэгдүүлж орон нутгийн санхүүгийн чадавхийг сайжруулна.

2.3. Уул уурхайгүй "Эко хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого" сумын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, бэлчээрийн даацад тохирсон уламжлалт мал аж ахуйг эдийн засгийн үр ашигтай эрхлэх бодлого барина.

2.4. Мал эмнэлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хувийн мал эмнэлэг ажиллуулах хүсэлтэй эмч, мэргэжилтэнийг дэмжих, мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл бүс нутаг болгох.

2.5. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.6. Сайхан-Овоо сумын хөдөө аж, ахуйн гаралтай чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг төв суурин газрын /хот, аймаг/ зах зээлд нийлүүлэх нэрийн дэлгүүр байгуулахад дэмжлэг үзүүлж зээл тусламжинд хамруулах

2.7. Стандартын шаардлага хангасан мал нядлах цэгийн үйл ажиллагааг эхлүүлж тогтмолжуулан, эрүүл ахуйн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

2.8. Арьс, шир боловсруулах анхан шатны цехтэй болох.

2.9. Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж, төмс хүнсний ногооны хэрэглээний 50-аас доошгүй хувийг орон нутгаас хангах. Зуны хүлэмжийн аж ахуйг дэмжиж төмс хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлэх

2.10. Шилмэл мал, цагаан идээний болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах.

2.11. Инженерийн хийцтэй гүн өрмийн болон энгийн уурхайн худаг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг зохион байгуулна.

## 3. Хүрээлэн буй орчны хөгжил, аялал жуулчлалын салбарын сэргэлт

3.1. "Ногоон сум"хөтөлбөр батлуулан хэрэгжүүлнэ.

3.2. "Орхон-Онги" гол төслийг дэмжин ажиллана.

3.3. Сум тохижилтын журам боловсруулж сумын төвийн хог цуглуулах, тээвэрлэх ажлыг бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

481144213
ЗЮА0039 9033475

3.4. "Хоггүй цэвэрхэн сум" хөдөлгөөн өрнүүлж зориулалтын бус газар хог хаяхгүй дадал хэвшлийг төлөвшүүлэх, хөдөөгийн хур хогуудыг цэвэрлэнэ.

3.5. Өгөөдэй хааны өвлийн ордон Шаазант хотын түүхийг судлан дэлгэрүүлэх.

3.6. Сумын бахархал, онцлогийг харуулсан "Төгрөг хайрхан" аялал жуулчлалын төвийг шинээр барьж нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл чанар дизайныг сайжруулан хөгжүүлж орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.7. "GoMongolia" хөтөлбөрийн хүрээнд суманд зочлох гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ. Жуулчид үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах "Адууны баяр" эвент арга хэмжээг тогтмолжуулна.

3.8. Гэр бааз байгуулах иргэд, малчдыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.9. "Морин Хөтөл" орчимд сум руу орох, гарах замд 1 километрээс багагүй урттай ногоон зурвас ,цэцэрлэгт хүрээлэн бий болгож, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

## 4. Боловсрол, эрүүл мэндийн салбарын сэргэлт

4.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хамран сургалтыг нэмэгдүүлнэ

4.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, орчинг бүрдүүлэх. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох ,өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

4.3. ЕБСургуулийн сурагчдын өөрөө удирдах байгууллагыг дэмжин төлөвшүүлж, хүүхдийн багаас зөв дадал хэвшилд сургах.

4.4. "Шатар", "Шагай харваа" дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх.

4.5. ЕБСургуулийн гадна хөлбөмбөгийн талбай байгуулна.

4.6. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

4.7. Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, өвчтөний онош, зургийг цахим орчинд нарийн мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч эмчлэх боломжийг хангаж цахим шилжилтийг эрчимжүүлнэ.

## 5. Бүтээн байгуулалт, нутгийн хөгжлийн сэргэлт

5.1. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

5.2. Сумын төвийн иргэд, төрийн албан хаагчдыг хямд орон сууцаар хангах ажилд хувийн хэвшилтэй хамтран ажиллаж 24 айлын орон сууц барина.

4817144213
ЗЮА0039 9033475

5.3. Төрийн албан хаагчдыг ая тухтай тохилог орчинд иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжоор хангаж "Нутгийн удирдлагын ордон"-ын барилга шинээр барина.

5.4. Нутаг дэвсгэрийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөг боловсруулах

5.5. Сумын төвийн бохирын шугамыг ашиглалтанд оруулах, айл өрхийн дулаан, цэвэр шугамтай болгох ажлын эхлэлийг тавьж мэргэжлийн байгууллагаар ТЭЗҮ-г хийлгүүлэх

5.6. Сумын бизнес хөгжлийн төвийг тогтмол үйл ажиллагаанд оруулах, Жижиг дунд бизнес эрхлэгчид, спорт холбоодыг тохилог орчинд үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангаж байнгын байртай болгох

5.7. Төгрөг багт сүлжээний сайжруулалт хийнэ.

5.8. Шаардлага хангасан халуун усны тогтмол үйлчилгээг бий болгоно.

5.9. Сайхан-Овоо суманд соёлын төв шинээр барьж хуучин соёлын төвийг спорт цогцолбор хэлбэрээр засварлаж ашиглах

5.10. Өөр аймаг, суманд ажиллаж амьдарч байгаа нутгийн иргэд, нутгийн зөвлөлтэй хамтран "Шинэ санаа-330" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.11. Цахилгаан шугамын дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, 04-ын шугамын өргөтгөл хийнэ.

158

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/170

танай ____________ -ны № ____________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД
СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хулд сумын "Монгол ардын нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Хулд сумын "Монгол ардын нам"-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хулд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Хулд сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ...... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................../Б.ГАНТУЯА/

160

Дундговь аймгийн Хулд сумын Монгол Ардын
Намын хорооны 2024 оны 06 сарын 21-ний өдрийн
2 дугаар хурлын 02 тоот тогтоолоор батлав.

# ХУЛД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**УРИА: ХАМТДАА ЗҮТГЭЖ , ТҮРҮҮЛЖ ХӨГЖЬЕ**

"Алсын харaa-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого""Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ" суурилсан мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 23 зорилт, 77 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

ДООРХ БОДЛОГУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАНА

1. Иргэний хөгжлийн бодлого
2. Сайн засаглалын бодлого
3. Хөдөө аж ахуйн бодлого
4. Эдийн засгийн бодлого
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын бодлого

## НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- ✓ Эрүүл иргэн
- ✓ Боловсролтой иргэн
- ✓ Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
- ✓ Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлэх
- ✓ Ажилтай, орлоготой иргэн
- ✓ Хүүхэд, Залуучуудын хөгжлийн төв
- ✓ Ахмадын хөгжлийг дэмжинэ
- ✓ Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ
- ✓ Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

## ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- ✓ Мэргэшсэн чадварлаг төрийн алба
- ✓ Хүнд суртал гүй - Төрийн алба
- ✓ Шилэн тендерийг зохион байгуулна

3171144213
ЗЮА0039 0083475

- ✓ Хариуцлагатай уул уурхайг бий болгоно
- ✓ Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ

**ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО**

- ✓ Малчдын амьжиргааг сайжруулна
- ✓ Малчдын эрүүл мэнд
- ✓ Бэлчээрийн менежментийг сайжруулна, ойн зурвас байгуулах

**ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- ✓ Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ
- ✓ Аялал жуулчлал бий болгоно
- ✓ Төр, хувийн хэвшлийн түншлэл
- ✓ Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна

**ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО**

4817144213
ЗЮА0039 9033475

162

# 1. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

## 1.1 Эрүүл иргэн.

1.1.1 "Эрт илрүүлэг" хөтөлбөрийг үргэлжлүүлж өвчлөлөөс урьдчилан иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах

1.1.2 "Эрүүл шүд, эрүүл хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх "Эрүүл байхын үндэс" хөтөлбөр хэрэгжүүлнэ

1.1.3 Хулд сумын эрүүл мэндийн төвд моорог, граж барих

1.1.4 Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна

1.1.5 Эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна орон сууцжуулах

## 1.2. Боловсролтой иргэн

1.2.1 Багш нарын хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж " Чадварлаг багш " хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

1.2.2 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага ба ерөнхий боловсролын сургуулийг шинээр барьж эхлүүлэх

1.2.3 Байгалийн ухаан болон бусад хичээлийн төрөлжсөн олимпиадыг улс болон бүсийн хэмжээнд зохион байгуулахад багш хүүхдийг хамруулахад дэмжлэг үзүүлнэ

1.2.4 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, орон сууцжуулах

## 1.3 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн

1.3.1 "Монгол уран бүтээл", үндэсний болон загварын хувцас үйлдвэрлэгчдийг дэмжиж загварын шоу хийж сурталчилан таниулах

1.3.2 Аймгийн соёл, урлагийн өдөрлөгийг зохион байгуулахад оролцоно

1.3.3 Хүүхэд залуучуудын дунд гоо зүй, соёл урлаг, түүх ёс заншлын дугуйлан сургалт хичээллүүлэх

## 1.4 Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн

1.4.1 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, явган алхах, дугуй унах, зэрэг ажлуудыг хэвшил болгоно

1.4.2 Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх усан бассейн, фитнес заал, орчин үеийн сагс, волейболын талбай тоглоомын талбай усан оргилуур бүхий цэцэрлэгт хүрээлэнтэй болох

**1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, оролцоог нэмэгдүүлэх**

1.5.1 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэнд ажлын байр бий болгож ажил олгогчид санхүүгийн урамшуулал олгож, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэнийг ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх, төлбөрийн хэмжээ, төрийн байгууллагын удирдах ажилтны хариуцлагыг нэмэгдүүлнэ

**1.6 Ажилтай, орлоготой иргэн**

1.6.1 Сум хөгжлийн сангаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ

1.6.2 Өрх бүрийг үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хөдөлгөөн өрнүүлэн дэмжиж ажлын байр бий болгох

1.6.3 Их дээд болон мэргэжлийн сургууль төгссөн залуучуудыг орон нутагтаа ажиллах боломж нөхцөлөөр хангаж бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж зах зээлтэй нь холбож өгөх

1.6.4 Зорилтод бүлгийн иргэдийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран нэгдэж нийлж, хоршиж ажиллахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

**1.7 Хүүхэд, Залуучуудын хөгжлийг төв**

1.7.1 Залуучууд хөгжлийн төвтэй болох, залуучуудын холбооны үйл ажиллагааг сайжруулах

1.7.2 Оюутан, Залуучууд, өсвөр үеийнхний дунд спортын олон төрөлт арга хэмжээг жилд 2-оос дээш удаа зохион байгуулах

1.7.3 Залуучуудын чуулга уулзалтыг жилд нэг удаа зохион байгуулах

1.7.4 Сумын иргэдийн дунд урлаг, спортын наадам зохион байгуулж, шигшээ багтай болж бүсийн тэмцээнүүдэд амжилттай оролцох

1.7.5 Сумын аварга шалгаруулах уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулна

1.7.6 Бөхийн холбооны үйл ажиллагааг сайжруулж үндэсний бөх, жүдо бөх болон бусад бөхийн төрлөөр хүүхэд залуучуудыг хамруулж дэвжээтэй болох

1.7.7 Шагайн харваа болон теннис биллиардын заал тохижуулах

**1.8.1 Ахмадын хөгжлийг дэмжинэ**

1.8.1 Ахмад настны мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэн ахмадын байрыг тохижуулна

1.8.2 Ахмадуудын урлаг, спортын наадмыг зохион байгуулна

4817144213
ЗЮА0039 9033475

1.8.3 Ахмад настан, залуучууд, хүүхэд багачуудын гурван үеийн уулзалтыг зохион байгуулна

1.8.4 "Ахмад настны хөгжил хамгааллын үндэс"-ний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

1.8.5 Хөдөлмөрийн чадвартай ахмадуудыг нэмэлт орлоготой болох боломжийг бүрдүүлнэ

**1.9 Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ**

1.9.1 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг чанаржуулна

1.9.2 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад дөхөм болгож ажлын байранд зуучлах

1.9.3 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна

**1.10. Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил**

1.10.1 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, хурд сааруулагч, таних тэмдэг, камертай болгоно

1.10.2 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлнэ

1.10.3 Эмэгтэйчүүдийн товлолт дархлаажуулалтыг нэвтрүүлж умайн хүзүүний хрот хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлнэ

## 2. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДОЛГО

**2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба**

2.1.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ

2.1.2 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлж орон сууцжуулах

2.1.3 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна

**2.2 Хүнд сурталгүй - Төрийн алба**

2.2.1 Иргэд, олон нийттэй харилцах мэдээллийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж төр иргэний эргэх холбоог сайжруулна

2.2.2 Төрийн цахим үйлчилгээний системийг түгээн дэлгэрүүлж ашиглаж сургах

**2.3 Шилэн тендерийг зохион байгуулна**

4817144213
ЗЮА0039 9033475

2.3.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно

2.3.2 Сумын бүх төрийн байгууллагуудын "шилэн данс"-ыг хөтлүүлж хяналт тавьж ажиллана

2.3.3 Орон нутгийн ХХК-г дэмжиж ажиллах

**2.4 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно**

2.4.1 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ

2.4.2 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч зам талбайг засаж янзлах, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана

2.4.3 Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтлах, ашигт малтмалын хайгуул, ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг жилд хийлгэх.

2.4.4 Бичил уурхай ашиглаж байсан талбайд хайгуул хийлгэж улмаар орон нутгийн өмчид ХК-г байгуулж сум орон нутгийн өгөөжийг нэмэгдүүлнэ.

**2.5 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ**

2.5.1 Гэр хорооллыг цэвэр усны шугамд холбож хүлэмжийн аж ахуйг дэмжинэ

2.5.2 Ойн зурвас байгуулж тариалангийн бүстэй болох

2.5.3 Тэрбум мод хөдөлгөөнд нэгдэж ногоон сум хөдөлгөөнийг өрнүүлэх

2.5.4 Хог хаягдлын менежментийг сайжруулна

## 3. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДОЛГО

**3.1 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна**

3.1.1 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах ажлыг жил бүр зохион байгуулна

3.1.2 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо техникчидийг бэлтгэж суманд ажиллуулна

3.1.3 Баг бүрт мал угаалгын газар барина

3.1.4 Шаардлагатай багт өвс тэжээлийн агуулах нэмж барина

**3.2 Малчдын эрүүл мэнд**

3.2.1 Малчдын эрүүл мэндийг хамгаалах эрт илрүүлэгт хамруулах

3.2.2 Хэрэглэж буй ундны усанд шинжилгээ хийх

**3.2 Бэлчээрийн менежментийг сайжруулна**

3.2.1 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж шаардлагатай бэлчээрт гүн өрмийн худаг гаргах

3.2.2 Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой байгальд халгүй энгийн механик арга болон микробиологийн аргыг хослуулан тэмцэж бэлчээрийг хамгаална

144213
ЗЮА0039 9023475

## 4. ЭДИЙН ЗАСГИЙН БОДОЛГО

**4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ**

4.1.1 Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжүүлнэ

4.1.2 Төмөр хийц тоног төхөөрөмжийн үйлдвэрийг дэмжих

4.1.3 Түүхий эдийн үйлдвэрлэлийг дэмжинэ

4.1.4 Барилгын туслах материал үйлдвэрлэлийг дэмжинэ

**4.2 Аялал жуулчлал бий болгоно**

4.2.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээ / Айрагны баяр, тэмээний баяр, Ардын урлагийн наадам г.м /- г сурталчлах

4.2.2 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин орлогыг нь нэмэгдүүлэх

**4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл**

4.3.1.Түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ

4.3.2 "Говь түншлэл" арга хэмжээг зохион байгуулж иргэдийг хамруулах

**4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна**

4.4.1 Үйлдвэр үйлчилгээ явуулдаг иргэдийг ажлын байртай болгох

4.4.2 Халуун ус ахуйн үйлчилгээний газартай болгох

## 5. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**Хулд сум :**

5.1.1 Сумын ЗДТГ-ын шинэ барилга эхлүүлэх

5.1.2 Ахуй үйлчилгээний газар бий болгох

5.1.3 Цэвэр бохирын шугамтай холбох

5.1.4 Ерөнхий боловсролын сургуулийг шинээр барих

5.1.5 Залуучууд хөгжлийн төвтэй болох

5.1.6 Наадмын талбайтай барих

5.1.7 Жишиг сум хөтөлбөрт хамрагдах

5.1.8 Шинэ цэцэрлэг барих

4817144213
ЗЮА0039 9033475

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/164

танай ____________ -ны № ____________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Цагаандэлгэр сумын “Монгол ардын нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Цагаандэлгэр сумын “Монгол ардын нам”-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Цагаандэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ...... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ................../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................/Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ..................../Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................./Б.ГАНТУЯА/

Цагаандэлгэр сумын Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгчдийн
2024 оны 6 сарын 22-ны өдрийн 4 тоот тогтоолын хавсралт

# ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН **МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

"Алсын хараа - 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "ШИНЭ ЗУУН – ШИНЭ СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийн хүрээнд 5 бүлэг 40 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

| Мөрийн хөтөлбөр | Зорилт, арга хэмжээ |
|---|---|
| Төрийн алба, сахилга хариуцлагын сэргэлт | • Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.<br>• Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.<br>• Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж, шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.<br>• Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /тендер/-г нээлттэй ил тод шилэн болгож, нийтэд тогтмол мэдээлнэ.<br>• Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ. |
| Ажлын байр, орлогын сэргэлт | • Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.<br>• Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг бодлогоор дэмжинэ.<br>• Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, сум дундын хоршоог байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.<br>• Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрөл, хангамжийг нэмэгдүүлнэ.<br>• Нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр стандартад нийцсэн үйлчилгээ эрхлэх санаачлагыг бүрэн дэмжинэ.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.<br>• Өөрийн нөөц боломцоогоо дайчлан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийг 3-аас доошгүй номинацаар шалгаруулж сурталчилна.<br>• Амрагч, аялагчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /боржигин найр, унаган тамга г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна. |

| | |
|---|---|
| Хөдөө аж ахуйн сэргэлт | • Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахыг хоршоогоор дамжуулан дэмжиж ажиллана.<br>• Зудын эрсдэлийг даван туулах "Өвөлжөө" төслийг эхлүүлж, зудад өртсөн малчдыг шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.<br>• Стандартын шаардлага хангасан өвс, тэжээлийн агуулах шинээр барьж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.<br>• Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.<br>• Дахин дамжуулах станцуудыг байгуулж, сумын хэмжээний бүх малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.<br>• Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.<br>• Эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр хангаж, Старлинкийн интернетэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ. |
| Хүн ам, боловсон хүчний сэргэлт | • Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.<br>• Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтнуудыг сургах бодлого хэрэгжүүлнэ.<br>• Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, ЕБС, СӨБ-ын байгууллагын багш нарыг сургаж, бэлтгэх бодлого баримтална.<br>• Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн, холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, томилно.<br>• Бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдад англи хэл эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, англи хэлний багш нарыг сургаж чадавхжуулахад дэмжлэг үзүүлнэ.<br>• Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээлтэй, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.<br>• Оношлогооны төвд 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар оношлуулж, зардлыг эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.<br>• Ахмадуудыг орон нутгийн сувилалд сувилуулах боломжийг бүрдүүлнэ.<br>• Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна.<br>• Үндэсний спортын төрөл болох шагайн харваа, сурын харвааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана. |

| | |
|---|---|
| Дэд бүтэц, тохижилтын сэргэлт | • 16 айлын орон сууц барина.<br>• Суманд төвийн шугам сүлжээ /Цэвэр, бохир усны шугам/ цэвэрлэх байгууламж шинээр барьж, сумын төвийн айл өрхийн амьдрах орчинг сайжруулна.<br>• Соёлын төвийн барилгыг 100 хувь ашиглалтад оруулна.<br>• Цахим худаг байгуулан ундны усны соёлтой боловсон үйлчилгээг хэвшүүлнэ.<br>• Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.<br>• “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоотой уялдуулна.<br>• Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг шинээр барина.<br>• Хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барина.<br>• Цэцэрлэг, сургуулийн дотоод, гадаад орчинг камержуулж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлнэ.<br>• Шаардлага хангасан халуун усны тогтмол үйлчилгээг бий болгоно. |

4817144213
ЗІОА0039 9033475

**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН**

**МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-07-17 № 01/174

танай ____________ -ны № ____________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Эрдэнэдалай сумын “Монгол ардын нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Эрдэнэдалай сумын “Монгол ардын нам”-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Эрдэнэдалай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр ( ......... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Сонгуулийн хороонды

Хавсралт .......... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ................./Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР ................./Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР ................./Т.БАТСАЙХАН/
АХЛАХ АУДИТОР ................./Б.ГАНТУЯА/

199

Эрдэнэдалай сумын Монгол Ардын Намын хорооны хурлын

2024 оны 06 сарын 22-ны өдрийн 03 тоот тогтоолын хавсралт

# 2024 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ: "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого","Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр", "Монгол Ардын Намын "Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028" зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрх гэрийн амьдралын чанарыг дээшлүүлэх "БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ-ЭХ НУТГИЙН СЭРГЭЛТ" мөрийн хөтөлбөрийг 6 үндсэн бүлэг, 17 дэд бүлэг, 130 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

1.1 Орон сууц
1.2 Эрүүл иргэн
1.3 Боловсролтой иргэн
1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого
- Хүүхэд
- Оюутан, залуучууд
- Гэр бүл
- Ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5 Хөдөлмөр эрхлэлт
1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
1.7 Эрүүл идэвхитэй амьдралтай иргэн

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин
3.2 Шинэ ажлын байр
3.3 Төрөлжсөн аялал жуулчлал

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

4.1 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
4.2 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

## ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

5.1 Тэрбум мод хөтөлбөр
5.2 Уламжлалт нүүдлийн аж ахуй
5.3 Үнэт баялаг ус

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

6.1 Бүтээн байгуулалт

6.2.Сумын хөгжил

200

# 1 НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### *1.1 Орон сууц*

1.1.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг өнөөгийн түвшнээс 5 дахин нэмэгдүүлнэ.

1.1.2 "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмадуудыг нэн түрүүнд хамруулна.

1.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.1.4 " 200 айлын орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### *1.2 Эрүүл иргэн*

1.2.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлэгт зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулна.

1.2.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлнэ.

1.2.3 Нарийн мэргэжлийн эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод сургах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.4 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.5 "Элэг бүтэн Монгол", хүүхдийн "Эрүүл шүд", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

1.2.6 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж "Эрт илрүүлэг" хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.7 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

### *1.3 Боловсролтой иргэн*

1.3.1 Эрдэнэдалай сумын хэмжээнд цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгуудыг бүрэн шинэчилж дуусгана.

1.3.2 Говийн бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлнэ.

1.3.3 Бүх шатны сургалтын байгууллагын суралцагч англи хэлийг эзэмших тэгш боломж бүрдүүлж, англи хэлний багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлнэ.

1.3.4 Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.3.5 Төгсөөд ажиллаж байгаа залуу багш нарт зориулсан түрээсийн орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ.

1.3.6 Багшлах хүний нөөцийг чадавхжуулж СӨБ, ЕБС багшийг гадаад, дотоодод сургаж, бэлтгэх бодлого баримтална.

1.3.7 "Багшийн хөгжлийн төв"-ийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.8 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.3.9 Багш нарыг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.

1.3.10 Багш нарын цахимаар ажиллах нөхцлийг бүрдүүлж, давхар ажиллаж, цалин орлогоо нэмэгдүүлэх боломжтой болгоно.

1.3.11 Ахмад багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санг байгуулна.

## 1.4 Хүн ам, нийгмийн бүлэг бүрт чиглэсэн нутгийн сэргэлтийн бодлого

### Хүүхэд

1.4.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг асрах үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулна.

1.4.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.4.5 Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.4.6 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

### Оюутан, залуучууд

1.4.7 Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

1.4.8 Хөдөлмөрийн хуулинд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж шинэ ажлын байр бий болгох бодлого баримтална.

1.4.9 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.4.10 Төгсөгчдөд зориулан “Хийнгээ суръя- Орлого олъё-Хэмнэе” загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.

1.4.11 Эрдэнэдалай сумын Залуучуудын хөгжлийн төв байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

### Гэр бүл

1.4.12 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.13 Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй тогтолцоог хөгжүүлнэ.

1.4.14 Цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах, тарах цагийг уртасгаж эцэг, эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.15 Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.

1.4.16 Айл өрхийн амьжиргааны түвшинг олон улсын аргачлалаар тогтоож, ажил орлоготой болгох, малжуулах, туслах аж ахуй эрхлэх зэргээр орлогын өсөлтийг дэмжих бодитой арга хэмжээг авч ажиллана.

### Ахмад настан

1.4.17 Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.18 Ахмадуудын хөдөлмөрийн хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын ажиллагааны санаачлагыг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.19 Ахмадын амралт сувилалд явж чаддагүй ахмадуудыг орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлнэ.

1.4.20 Түрээсийн орон сууцны хороолол байгуулж, ахмадуудаа хамруулан, төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэнэ.

1.4.21 Ахмадуудын урлаг, спортын наадмыг бүсчилэн зохион байгуулна.

1.4.22 Улаанбаатар хотод "Nura" оношлогооны төвд 60-аас дээш насны ахмадуудыг зохион байгуулалттайгаар хамруулж, зардлыг нь эрүүл мэндийн даатгал болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.

1.4.23 Суманд ахмадын хөгжлийн төвийг хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.4.24 Ахмад настнуудад өдрийн болон 7 хоногийн эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээнд хамруулна.

**Малчид**

***Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд:***

1.4.25 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах нөхцлийг бүрдүүлнэ.

1.4.26 Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

1.4.27 Говийн бүсийн хэмжээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэн, мал сүргийг бүрэн эрүүлжүүлнэ.

1.4.28 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

1.4.29 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах болон боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.4.30 Зудад өртсөн малчдыг нутгийн шилмэл омгийн малаар малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.4.31 Зудын эрсдэлийг даван туулах "ӨВӨЛЖӨӨ" төсөл хэрэгжүүлнэ.

1.4.32 Сумын эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр хангаж, Старлинкийн интернетэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.

1.4.33 Малчдын эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох ундны усыг стандартын түвшинд хүргэж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

1.4.34 Дахин дамжуулах станцуудыг байгуулж, малчин өрхүүдийг үүрэн холбооны сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлнэ.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

1.4.35 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.36 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг өргөжүүлнэ.

1.4.37 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

## 1.5 Хөдөлмөр эрхлэлт

1.5.1 Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах бодлого баримтлана.

1.5.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.5.3 Хүнсний нөөц нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулахад чиглэсэн аж ахуй эрхлэх, шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлагыг санхүү, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.5.4 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

### *1.6 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн*

1.6.1 "Уртын дууч, морин хуурчдын"-III их наадмыг зохион байгуулахад хамтран дэмжиж ажиллана.

1.6.2 Жил бүр соёл, урлагийн шилдэг ажилчдыг шалгаруулж гадаад, дотоодын арга хэмжээнд туршлага судлуулах, нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

1.6.3 Иргэдийн дунд урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулахыг дэмжин ажиллана.

### *1.7 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн*

1.7.1 Усан бассейн бүхий цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.

1.7.2 Иргэд идэвхитэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуйн зориулалтын зам талбайтай болно.

1.7.3 Сумын "Бага Олимп" спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 2.1 "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл"

2.1.1 Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.

2.1.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог төрийн дэмжлэгтэй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулж шинэчлэн байгуулна

2.1.3 Сумандаа говийн бүсийн гойд ашиг шимт цөм сүргийг бий болгоно.

2.1.4 Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.

2.1.5 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.

2.1.6 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.1.7 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах санаачлагыг дэмжинэ.

2.1.8 Сумандаа стандартын өвс, тэжээлийн агуулах нөөцийг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.9 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, сумын иргэдийн хэрэгцээг хангана.

2.1.10 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.1.11 Мах, сүү, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулж, дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.

2.1.12 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

2.1.13 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

### 3.1 Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин

3.1.1 Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.

3.1.2 Эрдэнэдалай суманд жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан бизнес инкубатор төв байгуулна.

3.1.3 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, болон дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдаа болон "дундговь түншлэл" арга хэмжээнд жил бүр үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин оролцуулж сурталчилна.

3.1.4 Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, шинээр боломжит улс орнуудтай харилцаа тогтооно.

## 3.2 Шинэ ажлын байр

3.2.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

3.2.2 Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

3.2.3 Хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.

3.2.4 Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.5 Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлогоор дэмжинэ.

3.2.6 Эрдэнэдалай сумын хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

3.2.7 Орон нутгийн байгалийн баялаг, ашигт малтмалд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрийг дэмжинэ.

### *3.3 төрөлжсөн аялал жуулчлал*

3.3.1 Суманд зочлох гадаад, дотоодын жуулчдын аялах тав тухтай орчин бүрдүүлэх.

3.3.2 Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.3.3 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээ /Айрагны баяр, тэмээний баяр, ардын урлагын наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулна.

3.3.4 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл иргэн, аж ахуй нэгжийг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.5 Аялал жуулчлалын гадаадад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа маркенгийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.3.6 Сумын орох гарах хаалга, олон нийтийн худалдаа үйлчилгээний төвүүдэд түшиглэн, ариун цэврийн байгууламж бүхий нийтийн бие засах газруудыг бий болгоно.

## ДӨРӨВ. ШУДАРГА, ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ

### 3.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

3.4.1 Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

3.4.2 Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

3.4.3 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.

3.4.4 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

3.4.5 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

3.4.6 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

### 3.5 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

3.5.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.5.2 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

3.5.3 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.

3.5.4 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгох.

## ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ СЭРГЭЛТ

### 3.6 “Тэрбум мод” хөтөлбөр

3.6.1 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй, оролцоотой ажил бизнесийг дэмжинэ.

3.6.2 Монгол орны ус цаг уурын орчны шинжилгээний салбарт өндөр технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн техникийн шинэчлэл хийж, цаг уур, гамшгийг эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана.

3.6.3 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

3.6.4 Ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

3.6.5 “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.

3.6.6 Сумын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн мод тарих идэвх сонирхлыг нэмэгдүүлнэ.

### 3.7 Уламжлалт нүүдлийн аж ахуй

3.7.1 Бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

3.7.2 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.7.3 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

3.7.4 Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

3.7.5 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

### 3.8 Үнэт баялаг ус

3.8.1 Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8.2 Суманд хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усны хайгуул судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлнэ.

## ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НУТГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**6.1 Бүтээн байгуулалт**

6.1.1 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.

6.1.2 Суманд хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр шинээр барьж, сумдын хог хаягдалын менежментийг сайжруулна.

6.1.3 6.1.3."Сангийндалай шинэ суурьшлын бүс"ийн цахилгаан хангамж /0,6кВ болон 0,4кВийн хувиарлах сүлжээ/-р бүрэн хангана.

6.1.4 Бохир зайлуулах шугам сүлжээг өргөтгөнө.

6.1.5 Хатуу хучилттай авто замыг дуусгаж шинээр зам нэмж тоосжилтыг багасгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

6.1.6 Борооны ус тогтдог автозамуудын ус зайлуулах шугамыг бүрэн шинэчилнэ.

6.1.7 Гэр хорооллын инжнерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

6.1.8 "Шинэ гудамж", "Шинэ хороолол" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.1.9 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон, хаус/ орон сууцны хангамжыг нэмэгдүүлж, инжнерийн хангамжтай сууцаар хангана.

6.1.10 Хуучин ашиглалтгүй болсон барилгуудыг буулгаж, орчин үеийн шинэ барилга барих хувийн хэвшлийг дэмжинэ.

6.1.11 Сумын төвийн айл өрхийн нүхэн жорлонг эко 00 болгох ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ..

**6.2 "Сумын хөгжил" – нутгийн сэргэлт**

6.2.1 Эрдэнэдалай сумын 2-р хүүхдийн цэцэрлэг шинээр ашиглалтанд оруулна.

6.2.2 Суманд 3 километрээс багагүй урттай ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн бий болгож, иргэдийн амарч зугаалах , чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.